

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цемент шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **САГ-2026/85/НА-СТА-ТӨҮГ**

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг:
naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: В.Эрдэнэцогт
Утас: 261885 Цахим хаяг: erdenetsogt.v@audit.mn
Аудитор: Г.Батбилэг
Утас: 263533 Цахим хаяг: batbilegg@audit.gov.mn
Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг
Утас: 70169029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	12
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	13
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	23
5.1 Төлбөрийн акт.....	23
5.2 Албан шаардлага.....	24
5.3 Зөвлөмж	29
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	33

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ББМУЯ	Барилга, барилгын материал үйлдвэрийн яам
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХХОАТ	Хувь хүний
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/731

танай _____-ны № _____-т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т, 8 дугаар зүйлийн 8.1-т, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Цемент шохой ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Сөрөг дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулаагүй байна.

Сөрөг санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний олж авсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн нийт 558,326.5 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан, дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархсан байна. Тухайлбал:

- Бараа материалын дансанд насжилт өндөртэй 3046 нэр төрлийн 1,027,173 ширхэг 10,013.7 сая төгрөгийн хэрэгцээ, шаардлагаас илүү барааг худалдан авч нөөцөлсөн;
- Найдваргүй авлагын нөөц тооцох суурь болон хувь хэмжээг бодит байдалд нийцүүлэн тогтоогоогүй, санхүүгийн тайланд тусгагдсан 65,981.2 сая төгрөгийн авлагын үлдэгдэлд 35,746.1 сая төгрөгийг найдваргүй авлагын нөөц байгуулж, авлагын цэвэр үлдэгдэл 30,235.1 сая төгрөгөөр илэрхийлэгдсэн;
- Тайлант оны эцсийн 216 харилцагч байгууллагын 8,217.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэл, 574 харилцагчтай холбоотой 20,909.7 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл, 16,372.6 сая төгрөгийн зээлийн хүүгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар сонгон шалгаруулах 10 харилцагчтай холбоотой 5,135.6 сая төгрөгийн худалдан авалтыг шууд гэрээ байгуулан гүйцэтгэсэн, гэрээний үнийн дүнгээс хэтрүүлэн 16 харилцагчаас 5,980.7 сая төгрөгийн худалдан авалт хийсэн;

- Борлуулалтын орлогыг НББОУС-ын дагуу данс бүртгэлд тусгасан 40,884.7 сая төгрөгийн борлуулалтын орлогыг борлуулалтын авлага дансанд тооцоо үүсгэж бүртгээгүй;
- Авлигатай тэмцэх газрын захиалгаар 2022 онд хийгдсэн Аудитын дүгнэлтэд Бэйзмент ХХК-ийн хөрөнгө оруулалтыг 114,636,117.82 ам доллар буюу 157,525.5 сая төгрөг, төсөлд зарцуулсан зардлыг 33,602.9 сая төгрөг, нийт 190,796.4 сая төгрөгөөр баталгаажуулсан байхад компанийн урт хугацаат өр дансанд Хөгжлийн банканд төлөх өрийг 276,158.8 сая төгрөг, Худалдаа хөгжлийн банканд төлөх зээлийн өрийг 41,916.8 сая төгрөгөөр тайлагнасан нь тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй ба Цемент шохой ХХК-д хувийн хэвшлээс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ бодитой бүртгэгдсэн эсэх нь тодорхойгүй;
- Тээврийн хэрэгслийн данснаас түүвэрлэн 95 тээврийн хэрэгслийг хамруулан хяналтын тооллого хийхэд, 22 тээврийн хэрэгсэл эвдрэлтэй, ашиглалтгүй, 25 тээврийн хэрэгсэл тоногдсон, 2 тээврийн хэрэгсэл осолд орж ашиглах боломжгүй болсон, 7 тээврийн хэрэгсэл биетээр оршин байхгүй зэргээр 4,648.5 сая төгрөгийн 56 ширхэг зөрчилтэй тээврийн хэрэгсэл бүртгэлтэй;
- Өмнөх он болон тайлант онуудад нийт 36 харилцагчид барьцааны болон гэрээт борлуулагчийн гэрээг үндэслэн өмнөх худалдан авалтын төлбөрийг барагдуулаагүй байхад их хэмжээгээр цементийг үргэлжлүүлэн нийлүүлснээр нийт 12,343.4 сая төгрөгийн авлага хуримтлагдсан байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, 5.1.4, 8 дугаар зүйлийн 8.4, 6 дугаар зүйлийн 6.4.8, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 94.4, 99 дүгээр зүйлийн 99.1, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 16 дугаар зүйлийн 16.5, 17 дугаар зүйлийн 17.4, 28 дугаар зүйлийн 28.1.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19.1, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Цемент шохой ХХК-ийн ажиллагсад өөрсдийн дотоод нөөц бололцоог дайчлан Шохойн зуухны доторлогоо, Цементийн үйлдвэрийн 1, 2 дугаар тээрмийн засвар, Чулуунцарын үйлдвэрийн их засваруудыг хийж 1,781.8 сая төгрөгийг зарцуулснаас гадна Шохойн чулуу ангилан ялгах, шигшүүр бутлуурыг 2024 оноос эхлэн барьж 2025 онд ашиглалтад оруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Компанийн санхүүгийн тайланд бүртгэлтэй үндсэн хөрөнгөөс 215,664.1 сая төгрөг, урьдчилж төлсөн тооцоо дансанд хөрөнгө оруулалт нэртэй 1,212.0 сая төгрөг, биет бус хөрөнгийн дансанд хайгуул үнэлгээний хөрөнгөөр 4,892.7 сая төгрөгийн хөрөнгийг тус тус бүртгэсэн нь дансны ангилал зөрчсөнөөс гадна уул уурхайн хөрөнгөд шилжүүлэн бүртгэх хөрөнгө бүртгэгдсэн байх эрсдэлтэй байна.

Тус компанийн охин компани Хөтөл энержи дулаан ХХК-ийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхээр 2019 онд 7,843.6 сая төгрөгөөр санхүүжүүлж, авлагаар бүртгэсэн нь цаашид төлөгдөх эсэх нь тодорхойгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Цемент шохой ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 26 дугаар тогтоолоор компанийн бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн баталж 755 хүнийг ажиллуулах газар, хэлтэс дарга 10 хүнээр бууруулан баталсны дагуу 2026 оны 1 дүгээр сард зохион байгуулалтын ажлыг хийсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
			/төгрөгөөр/
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө	76,255,337,241.62	79,237,140,644.98
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	21,055,306.46	77,693,946.97
1.1.2	Дансны авлага	5,645,411,070.75	12,398,791,598.84
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	78,276,587.20	546,175,108.32
1.1.4	Бусад авлага	14,531,435,072.44	15,152,804,635.52
1.1.6	Бараа материал	52,122,259,447.01	47,703,447,535.88
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,249,138,191.76	2,683,492,359.95
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	61,568,620.00	128,542,513.50
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	546,192,946.00	546,192,946.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	76,255,337,241.62	79,237,140,644.98
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	221,664,067,013.52	215,664,045,392.23
1.2.2	Биет бус хөрөнгө	9,615,605,400.29	9,308,687,992.82
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	3,110,309,086.42	3,129,451,484.57
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	234,389,981,500.23	228,102,184,869.62
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	310,645,318,741.85	307,339,325,514.60
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	9,034,226,101.71	11,512,068,678.73
2.1.1.3	Татварын өр	18,803,243,539.73	19,410,070,011.91
2.1.1.4	НДШ–ийн өглөг	2,402,225,396.68	392,487,244.86
2.1.1.6	Хүүний өглөг	16,372,618,946.34	16,372,618,946.34
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	17,070,537,725.54	17,070,537,725.54
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,982,260,398.91	983,230,293.18
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	190,415,024.11	62,625,263.46
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	65,855,527,133.02	65,803,638,164.02
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	41,916,835,529.58	41,916,835,529.58
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	2,213,391,285.66	1,250,481,713.02
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	3,103,027,378.08	3,103,027,378.08
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	276,158,820,300.00	276,158,820,300.00
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	323,392,074,493.32	322,429,164,920.68
2.2	Өр төлбөрийн нийт дүн	389,247,601,626.34	388,232,803,084.70
2.3	Эздийн өмч	-	-
2.3.3	- хувьцаат	11,945,269,000.00	11,945,269,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	47,284,714,835.75	47,284,714,835.75
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-137,832,266,720.24	-140,123,461,405.85
2.3.11	Эздийн өмчийн дүн	(78,602,282,884.49)	(80,893,477,570.10)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	310,645,318,741.85	307,339,325,514.60

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	71,356,825,536.76	84,464,828,334.22
2	Борлуулалтын өртөг	60,510,196,418.85	78,842,330,092.84
3	Нийт ашиг(алдагдал)	10,846,629,117.91	5,622,498,241.38
4	Түрээсийн орлого	3,434,181.82	-
5	Хүүгийн орлого	8,993,021.00	125,250,190.79
8	Бусад орлого	944,204,526.01	1,837,041,454.38
9	Борлуулалт, маркетингийн зардал	2,940,933,195.99	2,902,973,454.33
10	Ерөнхий ба удирдлагын зардал	7,802,271,280.45	6,168,081,974.79
12	Бусад зардал	1,012,574,740.25	1,684,025,260.41
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(205,510.06)	481,707.28
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	47,276,119.99	(3,169,809,095.70)
19	Орлогын татварын зардал	27,469,337.86	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	19,806,782.13	(3,169,809,095.70)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	19,806,782.13	(3,169,809,095.70)
24	Орлогын нийт дүн	19,806,782.13	(3,169,809,095.70)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,945,269,000.00	420,000,000.00	41,284,046,790.95	5,428,771,474.66	(127,338,699,811.01)	(68,260,612,545.40)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	741,816,184.18	741,816,184.18
Залруулсан үлдэгдэл	11,945,269,000.00	420,000,000.00	41,284,046,790.95	5,428,771,474.66	(126,596,883,626.83)	(67,518,796,361.22)
Өмчид гарсан өөрчлөлт	-	(420,000,000.00)	-	(5,428,771,474.66)	-	(5,848,771,474.66)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	(11,255,189,875.54)	(11,255,189,875.54)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	19,806,782.13	19,806,782.13
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	6,000,668,044.80	-	-	6,000,668,044.80
2024 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	11,945,269,000.00	-	47,284,714,835.75	-	(137,832,266,720.24)	(78,602,282,884.49)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	878,614,410.09	878,614,410.09
Залруулсан үлдэгдэл	11,945,269,000.00	-	47,284,714,835.75	-	(136,953,652,310.15)	(77,723,668,474.40)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	(3,169,809,095.70)	(3,169,809,095.70)
2025 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	11,945,269,000.00	-	47,284,714,835.75	-	(140,123,461,405.85)	(80,893,477,570.10)

/төгрөгөөр/

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	64,876,062,610.43	76,297,184,916.39
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	64,250,326,219.59	75,469,553,119.86
1.1.4	Буцаан авсан албан татвар	56,427,763.37	121,763,104.73
1.1.6	Бусад мөнгөн орлого	569,308,627.47	705,868,691.80
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	62,546,293,870.83	74,316,446,909.95
1.2.1	Ажиллагчдад төлсөн	18,696,528,870.19	20,157,746,228.80
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	4,065,327,093.35	7,833,175,987.48
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	13,247,764,802.69	18,777,104,548.11
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	10,808,078,562.13	13,807,790,228.41
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	10,450,704,204.67	5,636,658,007.94
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	894,087.95	12,481,873.63
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	3,936,874,607.76	6,973,665,248.01
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,340,121,642.09	1,117,824,787.57
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,329,768,739.60	1,980,738,006.44
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	8,993,021.00	125,250,190.79
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	8,993,021.00	125,250,190.79
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(2,559,965,299.30)	(2,049,831,264.00)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(2,559,965,299.30)	(2,049,831,264.00)
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,550,972,278.30)	(1,924,581,073.21)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	157,257.43	602,408.94
3.1.4	Валютын ханшийн тэгштгэлийн ашиг	157,257.43	602,408.94
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(362,767.49)	(120,701.66)
3.2.5	Валютын ханшийн тэгштгэлийн алдагдал	(362,767.49)	(120,701.66)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(205,510.06)	481,707.28
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(221,409,048.76)	56,638,640.51
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	242,464,355.22	21,055,306.46
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	21,055,306.46	77,693,946.97

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 оны		Хэлбэлзэл		Биелэлт	
				Төсөв	Гүйцэтгэл	2025Т/Г	2025Г/2024Г	2025Т/Г	2025Г/2024Г
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	мян тн							
1.1	Цемент	мян тн	220.5	400.0	281.4	(118.6)	60.8	70%	128%
1.2	Шохой		35.3	31.5	31.4	(0.1)	(4.0)	100%	89%
2	Уулын ажил	мян мЗ				-	-		
2.1	Уулын цул гаргалт:	мян тн	736.8	917.0	743.7	(173.3)	6.9	81%	101%
2.2	Олборлох шохойн чулуу нийт	мян тн	514.5	478.9	579.8	100.9	65.3	121%	113%
2.3	Шохойн чулуу-Хөтөл -1 орд	мян тн	514.5	388.8	579.8	191.0	65.3	149%	113%
2.4	Шохойн чулуу-Хөтөл -2 орд	мян мЗ	-	90.1	-	(90.1)	-	0%	0%
2.5	Хөрс хуулалт:	мян мЗ	545.6	738.9	528.1	(210.8)	(17.4)	71%	97%
2.6	Хөрс хуулалт- Хөтөл-1 орд	мян мЗ	545.6	648.8	528.1	(120.7)	(17.4)	81%	97%
2.7	Хөрс хуулалт- Хөтөл-2 орд		-	90.1	-	(90.1)	-	0%	100%
2.8	Хөрс хуулалтын дундаж харьцаа		1.06	1.54	0.91	(0.6)	(0.1)	59%	86%
3	Боловсруулалт:								
3.1	Чулуунцар	мян тн	200.0	350.0	229.7	(120.3)	29.7	66%	115%
3.2	Хуурай хольц	мян тн	322.5	560.0	369.2	(190.8)	46.6	66%	114%
3.3	Буталсан шохойн чулуу нийт	мян тн	432.0	588.2	470.7	(117.4)	38.7	80%	109%
3.4	Хуурай аргын бутлуур	мян тн	325.7	534.6	370.6	(164.0)	44.9	69%	114%
3.5	Шохойн үйлдвэрийн бутлуур	мян тн	106.3	53.6	100.1	46.5	(6.2)	187%	94%
4	Бүтээгдэхүүн борлуулалт								
4.1	Цемент	мян. тн	217.9	400.0	290.2	(109.8)	72.3	73%	133%
4.2	Шохой	мян тн	37.6	31.5	34.1	2.6	(3.4)	108%	91%
5	Нийт орлого	мян. төг	72,313,251.8	109,949,543.6	86,427,601.7	(23,521,941.9)	14,114,349.9	79%	120%
5.1	Үйл ажиллагааны орлого:	мян. төг	70,950,572.0	109,299,116.6	84,285,789.0	(25,013,327.6)	13,335,217.1	77%	119%
5.1.1	Цемент	мян. төг	59,513,361.0	98,782,256.6	73,729,279.5	(25,052,977.1)	14,215,918.5	75%	124%
5.1.2	Шохой	мян. төг	11,437,211.0	10,516,860.0	10,556,509.5	39,649.5	(880,701.4)	100%	92%
5.2	Үйл ажиллагааны бус орлого:	мян. төг	1,362,679.8	650,427.0	2,141,812.7	1,491,385.7	779,132.9	329%	157%
6	Нийт зардал	мян. төг	72,265,975.6	106,197,764.4	89,597,410.8	(16,600,353.6)	17,331,435.1	84%	124%
6.1	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	мян. төг	60,510,196.4	94,871,947.6	78,797,412.7	(16,074,534.9)	18,287,216.2	83%	130%
6.2	Борлуулалт маркетингийн зардал	мян. төг	2,940,933.2	3,637,270.3	2,902,973.5	(734,296.8)	(37,959.7)	80%	99%
6.3	Ерөнхий ба удирдлагын зардал	мян. төг	7,802,271.3	5,224,604.2	6,168,082.0	943,477.8	(1,634,189.3)	118%	79%
6.4	Үйл ажиллагааны бус зардал	мян. төг	1,012,574.7	2,463,942.3	1,728,942.6	(734,999.7)	716,367.9	70%	171%
7	Шилжих өртөг	мян. төг	5,982,078.4	1,038,330.4	(4,940,163.4)	(5,978,493.9)	(10,922,241.9)	476%	-83%
8	Татварын өмнөх ашиг	мян. төг	47,276.1	3,751,779.2	(3,169,809.1)	(6,921,588.3)	(3,217,085.2)	84%	-6705%

Цемент шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

9	Цэвэр ашиг	мян. төг	19,806.8	3,247,215.4	(3,169,809.1)	(6,917,024.5)	(3,189,615.9)	98%	-16004%
10	Төсөвт төлөх татвар шимтгэл	мян. төг	8,689,342.5	26,938,965.2	19,547,991.3	(7,390,973.9)	10,858,648.8	73%	225%
10.1	ААНОАТ	мян. төг	33,050.9	122,882.8	500,000.0	377,117.2	466,949.1	407%	1513%
10.1	НӨАТ	мян. төг	1,381,436.9	9,127,250.1	7,503,424.9	(1,623,825.2)	6,121,988.0	82%	543%
10.1	АМНАТ	мян. төг		454,393.3	435,163.6	(19,229.7)	435,163.6	96%	0
10.1	Бусад	мян. төг	7,274,854.7	14,234,439.0	11,109,402.8	(3,125,036.2)	3,834,548.1	78%	153%
11	Ногдол ашиг	мян. төг		3,000,000.0		(3,000,000.0)		0%	0%
12	Ажиллагсдын тоо	хүн	752.0	765.0	745.0	(20.0)	(7.0)	97%	99%
13	Цалингийн сан	мян. төг	23,462,933.5	25,377,129.7	25,361,190.5	(15,939.2)	1,898,257.1	100%	108%
14	Ажиллагсдын сарын дундаж цалин	төг	2,600,059.10	2,764,393.20	2,836,822.20	72,429.00	236,763.10	103%	109%
15	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.00	0.97	1.04	0.71	1.23	1.1	104%
16	Борлуулсан бүтээгдэхүүний нэгжийн өртөг								
16.1	Цемент	төг тн	224,587.0	235,507.0	267,384.8	31,877.8	42,797.8	114%	119%
16.2	Шохой	төг тн	311,266.6	380,778.0	351,435.2	(29,342.8)	40,168.6	92%	113%
17	Хөрөнгө оруулалт	мян.төг	8,227,675.4	11,292,831.9	6,794,225.6	(4,498,606.2)	(1,433,449.8)	60%	83%
18	Нийт авлага	мян.төг	59,522,081.2	51,837,520.1	66,343,565.1	14,506,045.0	6,821,483.8	128%	111%
19	Нийт өглөг	мян.төг	65,855,527.1	68,257,752.5	65,201,501.3	(3,056,251.2)	(654,025.8)	96%	99%
20	Ханшийн төсөөлөл	төг	3,381.02	3,381.02	3,577.48	196.46	196.46	106%	106%
21	Үнийн төсөөлөл	төг							
21.1	Цемент	төг	272,228	246,956	254,061	7,105	(18,167)	103%	93%
21.2	Шохой	төг	316,715	333,869	309,123	(24,745)	(7,591)	93%	98%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Хөтөлийн цемент, шохойн комбинат нь ББМҮЯ-ны сайдын 1983 оны 127 дугаар тоот тушаалаар цемент, шохой, уулын олборлох үйлдвэр, засвар механикийн контор, дулааны станц гэсэн бүтэцтэйгээр анх үүсгэн байгуулагдсан ба 1984 онд шохойн үйлдвэрийн I зуухыг галлаж үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

Хөтөл 1, Хөтөл 2 шохойн чулуун ордны ил уурхайгаас жилдээ 1 орчим сая тонны олборлолт явуулж, Шохойн болон Чулуунцрын үйлдвэрийг түүхий эдээр ханган ажилладаг. Чулуунцрын үйлдвэр нь хагас боловсруулсан бүтээгдэхүүн (клинкер) үйлдвэрлэж, цементийн үйлдвэрт нийлүүлдэг бол Цементийн үйлдвэр нь эцсийн бүтээгдэхүүн болох 32.5, 42.5, 52.5 маркийн цемент үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлдэг.

Цемент шохой ХХК-ийн охин компани Хөтөл энерги дулаан ХХК нь дулаан үйлдвэрлэж, Хөтөл хотын байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийг дулаанаар ханган ажиллаж байна.

Цемент шохой ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит бус хурлаар Засгийн газрын 2023 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн “Цемент шохой ТӨХК-ийн талаар авах арга хэмжээний тухай” 258 дугаар тогтоол, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 62 дугаар зүйлийн 62.1.4-д заасныг үндэслэн 2023 оны 10 дугаар сарын 31-нд ТӨХК байсныг Хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчилсөн.

Компани нь 100 хувь төрийн өмчит компани бөгөөд төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Засгийн газраас эрх олгосны дагуу Эрдэнэс Монгол ХХК-ийг тогтоосон.

Компани зорилго нь: Төр, хувийн хэвшил, ард түмний тэгш өмчлөлтэй, ил тод, цахим засаглалтай, Монгол Улсын болон олон улсын стандартад нийцсэн цемент, шохой үйлдвэрлэн дотоодын зах зээлийг бүрэн хангаж, экспортод гаргах, улс орны болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулан, хувьцаа эзэмшигчдэд ашиг хүртээх, сайн чанарын бүтээгдэхүүнээр шударга өрсөлдөн, баялаг бүтээнэ гэж тодорхойлсон.

Үйл ажиллагааны чиглэл нь:

- Шохойн ордны хайгуул, судалгаа болон олборлолт, борлуулалтын үйл ажиллагаа
- Барилгын материал цемент, шохой үйлдвэрлэх, борлуулах
- Ашигт малтмал ашиглалт
- Дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаан хангах
- Зочид буудлын үйлчилгээ
- Барилгын засал чимэглэлийн ажил, үйлчилгээ
- Зөвхөн ажиллагсдын эрүүл мэнд, чийрэгжүүлэлтэд зориулсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Цемент шохой ХХК нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Ашигт малтмалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төсвийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Ашигт малтмалын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Сургалтын төвийн үүл ажиллагааны журам
- Бүтээгдэхүүн худалдан борлуулах үйл ажиллагааны журам
- Илүү цагаар ажиллуулах журам
- Зочид буудал ажиллуулах журам
- Бараа материалын агуулахын журам

- Мөнгөн кассын үйл ажиллагааны журам
- Авлага ангилах, бүртгэх болон барагдуулах журам

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ, эрсдэлийн удирдлагын хэлтэс нь 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2025 онд “Хяналт шалгалтыг чанартай гүйцэтгэж, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж ажиллах” зорилт дэвшүүлэн 19 асуудлыг хянаж зөвлөмжийг холбогдох газар, хэлтэст хүргүүлсэн боловч зөвхөн 3 асуудлын зөвлөмж 73.0-76.0 хувийн биелэлттэй, 16 асуудалд хамаарах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цемент шохой ХХК нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Компани нь “Цемент шохой” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2024 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн А/05 тушаалаар баталж, бэлтгэсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон үйл ажиллагаандаа ашигладаг.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон боловч, зарим тусгай бодлогод өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Цемент шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,306.0 сая төгрөгөөр бурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	21,055.3	77,693.9	56,638.6
Авлага	20,255,122.8	28,097,771.3	7,842,648.5
Бараа материал	52,122,259.4	47,703,447.5	(4,418,811.9)
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	3,249,138.2	2,683,492.4	(565,645.8)
Бусад эргэлтийн хөрөнгө	61,568.6	128,542.6	66,974.0
Эргэлтийн бус хөрөнгө	546,192.9	546,192.9	-
Үндсэн хөрөнгө	234,389,981.5	228,102,184.9	(6,287,796.6)
Нийт хөрөнгийн дүн	310,645,318.7	307,339,325.5	(3,305,993.2)
Өр төлбөр	389,247,601.6	388,232,803.1	(1,014,798.5)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	(78,602,282.9)	(80,893,477.6)	(2,291,194.7)
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	310,645,318.7	307,339,325.5	(3,305,993.2)

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтүүдээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал/тооцоо, эргэлтийн бус хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч данстуудад материаллаг дүнгээр дараах өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 56.6 сая төгрөгөөр өссөн нь өмнөх оны борлуулалтын авлагаас 13,108.0 сая төгрөг орсон, бусад мөнгөн орлого 136.5 сая төгрөгөөр өссөн, хүүний орлогод 125.2 сая, хүү торгуулийн орлогод 89.4 сая төгрөг тус тус хүлээн авсан нь голлон нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 28,097.8 сая төгрөг болж, 7,842.6 сая төгрөгөөр өссөн нь дансны авлага 6,753.4 сая төгрөгөөр, нэмэгдсэн өртгийн албан татварын авлага 467.8 сая төгрөгөөр, бусад авлага 621.3 сая төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 47,703.4 сая төгрөг болж, 4,418.9 сая төгрөгөөр буурсан нь бэлэн бүтээгдэхүүн, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, сэлбэг 5,841.1 сая төгрөгөөр буурч, түүхий эд материал, шатах тослох материал, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл 1,422.3 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 565.6 сая төгрөгөөр буурч, бусад эргэлтийн хөрөнгө 66.9 сая төгрөгөөр өссөн нь Хөтөл 2 дугаар орд дээр ашиглалтад оруулсан түлшний савтай холбоотой гарсан зардлыг залруулан бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,287.8 сая төгрөгөөр буурсан нь Шүүхийн шийдвэрээр 377.0 сая төгрөгийн орон сууцыг барилга байгууламжийн дансанд бүртгэсэн мөн тээврийн хэрэгсэл 3,620.0 сая төгрөг, машин тоног төхөөрөмж 2,108.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, тайлант оны элэгдлийн зардал 12,875.9 сая төгрөг байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,014.8 сая төгрөгөөр буурсан нь татварын өр 1,400,1 сая төгрөгөөр, урьдчилж олсон орлого 999.0 сая төгрөгөөр тус тус буурсан зэрэг нь нөлөөлсөн.

Засгийн газрын хувь оролцоо буюу эздийн өмч оны эхнээс 2,291.2 сая төгрөгөөр буурч 80,893.5 сая төгрөг болсон нь тайлант оны хуримтлагдсан ашиг буурсантай холбоотой байна.

Тус газрын санхүүгийн тайланд 299.9 сая төгрөгийн дараах хэрэглээний программууд бүртгэлтэй байна. Үүнд:

- Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 7.3 сая төгрөгийн Diamond financial accounting программ;
- Үйлдвэрийн автоматжуулалтын 13.1 сая төгрөгийн Power scada operation программ;
- Зарлан мэдээлэх системийн 2.4 сая төгрөгийн программ;
- Геологи хайгуул, уул уурхайн төлөвлөлтийн 113.3 сая төгрөгийн Beyond программ;
- Геологи хайгуул, уул уурхайн төлөвлөлтийн 111.1 сая төгрөгийн Origin программ;
- Ил уурхайн төлөвлөлтийн 59.9 сая төгрөгийн программ тус тус бүртгэлтэй байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Цемент шохой ХХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 08-ны 25 дугаар тогтоолоор эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тодотгон нийт орлогыг 109,949.5 сая төгрөг олж, 106,197.8 сая төгрөгийн зардал гарган 3,751.8 сая төгрөгийн ашигтай ажиллах, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 11,292.8 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Тайлант онд нийт 109,949.5 сая төгрөг орлого олж, 106,197.8 сая төгрөг зардал гарган 3,751.8 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 86,427.6 сая төгрөг орлого олж, 89,597.4 сая төгрөгийн зардал гарган татварын дараах байдлаар 3,169.8 сая

төгрөгийн алдагдалтай ажилласан, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 6,794.2 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2025 оны		Биелэлт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Нийт орлого	мян. төг	109,949,543.6	86,427,601.7	(23,521,941.9)	79%
1.1	Үйл ажиллагааны орлого:	мян. төг	109,299,116.6	84,285,789.0	(25,013,327.6)	77%
1.1.1	Цемент	мян. төг	98,782,256.6	73,729,279.5	(25,052,977.1)	75%
1.1.2	Шохой	мян. төг	10,516,860.0	10,556,509.5	39,649.5	100%
1.1.3	Үйл ажиллагааны бус орлого:	мян. төг	650,427.0	2,141,812.7	1,491,385.7	329%
2	Нийт зардал	мян. төг	106,197,764.4	89,597,410.8	(16,600,353.6)	84%
2.1	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	мян. төг	94,871,947.6	78,797,412.7	(16,074,534.9)	83%
2.2	Борлуулалт маркетингийн зардал	мян. төг	3,637,270.3	2,902,973.5	(734,296.8)	80%
2.3	Ерөнхий ба удирдлагын зардал	мян. төг	5,224,604.2	6,168,082.0	943,477.8	118%
2.4	Үйл ажиллагааны бус зардал	мян. төг	2,463,942.3	1,728,942.6	(734,999.7)	70%
3	Татварын өмнөх ашиг	мян. төг	3,751,779.2	(3,169,809.1)	(6,921,588.3)	(84%)

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Тухайлбал:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 26 дугаар тогтоолоор 765 орон тоог бууруулж 755 орон тоог баталсан. Энэ нь компанийн нийт орон тоог 2 хувиар бууруулсан үзүүлэлттэй боловч тус байгууллагын хувьд хүнд, хортой, халуун нөхцөлд ажилладаг тул захиргааны нэгжүүдээс 10 орон тоог бууруулж захиргааны ажилчдын тоог 8-9 хувиар бууруулсан байна.
- Цемент шохой ХХК болон Үйлдвэрчний эвлэлийн хорооны 2025-2026 онд мөрдөх хамтын гэрээнд заалтын дагуу нэг өдрийн хоолны хөнгөлөлтийг 5.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна. Ажилчдын нэг өдрийн хоолны хөнгөлөлтөд нийт 738.6 сая төгрөгийг зарцуулжээ.
- Тус байгууллага нь Харилцагчийн өдөрлөг, Дархан Барилга экспо, Mining week, Цемент экспо зэрэг арга хэмжээнд оролцоход 18.2 сая төгрөгийг зарцуулсан.
- Төрд учирсан хохирол судалгаагаар
 - "Рийвэр стөун пропертис" ХХК-тай байгуулсан 2020/09/16-ны өдрийн №RPS-20/22-19 тоот "Цемент худалдах, худалдан авах гэрээ"-ний гүйцэтгээгүй үүрэг 909.0 сая төгрөг, хохирол 625.0 сая төгрөг, нийт 1,534.0 сая төгрөг гаргуулах, Мөн тэмдэгтийн хураамж 8.2 сая төгрөгийг хариуцах шүүхийн шийдвэр гарсан бөгөөд тус тооцоог зардлаар бүртгэсэн. Үүнтэй холбоотойгоор Авлигатай тэмцэх газарт гомдол гарсан бөгөөд хэрэг үүсгэж, шалгалт эхэлсэн.
 - Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Л.Наранбаатар нь үндэслэлгүйгээр ажилтнуудыг ажлаас чөлөөлсөн тул шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолоор тус компанийн 5 ажилтанд компаниас 315.6 сая төгрөгийн нөхөн олговор олгосныг

гүйцэтгэх захирал асан Л.Наранбаатараас гаргуулах тухай нэхэмжлэлийг Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр нэхэмжлэл гаргасан. Тус нэхэмжлэлийн хүрээнд 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 192/Ш32025/07393 тоот иргэний хэрэг үүсгэх тухай шүүхийн шийдвэр гарсан. Энэхүү асуудлын хүрээнд шүүхээр шийдвэрлэгдэх боломжтой бөгөөд хохирол барагдуулах ажил хийгдэж байна.

- “Хөтөл” ХХК-ийн “Цемент шохой” ХХК-д учруулсан 18 хэсгийн 374,601.7 сая төгрөгийн хохирлын хэрэгт холбогдох тооцоолол болон баримт материалыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, зарим хэсэгт холбогдох хэрэгт шинжээчийн дүгнэлт гарч 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 337,716.4 сая төгрөгийн хохирлын тооцоолол гарсан байна.
- Тайлант онд гадаад томилолтын зардал, хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цемент шохой ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд тус компанийн аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Цемент шохой ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох, нөөц өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулах, худалдан авах ажиллагаатай холбоотой бичиг баримтуудын иж бүрдлийг хангаж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Мишээл-Од Аудит ХХК-ийн ахлах аудитор М.Цэнд-Аюуш, аудитор П.Энхцэлмэг, М.Батмагнай, Б.Цогзолмаа нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Т.Одончимэг, чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг, Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Батбилэг, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Цемент шохой ХХК 2025 оны санхүүгийн тайлангаа Мишээл-Од Аудит ХХК-д 2026 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 01/203 дугаарын албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт орлогын 72,313.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 723.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага тэвчиж болох зардлуудыг гаргахгүй байх, зайлшгүй шаардлагатай зардлуудыг эрэмбэлэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 12,411.1 сая төгрөгийн 8 зөрчилд албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй шилэн дансны цахим хуудсанд 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 удаагийн 105.0 сая төгрөгийн орлого, 3

удаагийн 150.0 сая төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй, 17 удаагийн 3,508.4 сая төгрөгийн орлого, 42 удаагийн 3,236.1 сая төгрөгийн зарлагын гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.10-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй Төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга, Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн, авлага борлуулалтын нягтлан бодогч нарт хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад нийцлийн асуудалтай холбоотой 5,411.6 сая төгрөгийн 9 зөрчил илэрсэнд 5,411.6 сая төгрөгийн 7 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2 зөрчилд зөвлөмж өглөө

Илрүүлэлт 1: Тус компанийн захиргааны бүтэц хэт олон орон тоотой байгаагаас удирдлагын тогтмол зардал өндөр гарч, бүтээгдэхүүний өртөг, компанийн ашигт ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна. Мөн санхүүгийн албаны бүтэц зохион байгуулалт оновчгүй, ажлын ачаалал тэнцвэргүй, зарим ажлын зохион байгуулалт давхардсан олон хүний оролцоотой байна. Тухайлбал цалин хөлсийг бодоход төлөвлөлтийн албаны 4 эдийн засагч хийдэг, суутгах тооцооллыг санхүүгийн албаны нягтлан бодогч хариуцдаг зэргээр олон хүний оролцоо нь хяналт алдагдах, ажил цалгардах зэргээс шалтгаалан цалин хөлс буруу бодох эрсдэл гарч байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.2-т "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох", 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох", 19.2-т "Төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан энэ хуульд заасан хангамж, үйл ажиллагааны хязгаарлалтыг чанд мөрдөх ажилд хяналт тавьж, удирдах ажлыг хэрэгжүүлнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Тус албаны бүтэц зохион байгуулалтыг оновчтой зохион байгуулах, ажлын зохион байгуулалт давхардуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тайланг зөрүүтэй гаргасан, хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөртэй холбоотой зөрүүгийн тайлангийн тооцоолол хийгээгүй, санхүүгийн тайлан болон татварын тодорхойлолтоор татварын өрийн үлдэгдэл зөрүүтэй зэрэг татварын багц хуулийг мөрдөж ажиллаагүй байна.

Энэ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Энэ хуулийн 5.3-т заасан албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон, түүнчлэн гадаад улсаас олсон орлогод албан татвар ногдоно", Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журмын 1.2-т "Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан нь анхан шатны баримт, тооцоолол, ажлын баримтаар баталгаажиж, татварын албанд тайлагнасан аж ахуйн нэгжийн орлогын албан татварын ТТ-2 тайлангийн холбогдох дүнтэй нийцсэн байна", Нягтлан бодох бүртгэлийн тухай

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Татварын багц хуулийг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Хуулийн хэлтэс нь 90 харилцагчтай холбоотой 44,212.6 сая төгрөгийн авлагыг барагдуулах ажлыг хариуцаж хийхээс, тайлант онд 0.1 хувь буюу 49.3 сая төгрөгийн авлага барагдсан, 38.7 сая төгрөгийн авлагын шүүхийн шийдвэр гарсан бөгөөд авлагыг барагдуулах хангалттай арга хэмжээ аваагүй байна. Мөн Шүүхэд хүргүүлсэн 17 нэхэмжлэл холбогдох баримт материал хангалтгүйгээс буцаж, тэмдэгтийн хураамжид 9.8 сая төгрөгийг төлж, үр ашиггүй зардал гаргасан байна. Компанийн Удирдах зөвлөлөөс хүчин төгөлдөр мөрдөж байгаа дүрэм, журмуудын хэрэгжилтийг хянах талаар үүрэг өгсөн нь хэрэгжээгүй, тус компанийн хэмжээнд нийт хэдэн дүрэм, журам мөрдөж байгаа нь тодорхой бус байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-т "Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ", 208 дугаар зүйлийн 208.1-т "Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ", 208.2-т "Үүрэг гүйцэтгэх хугацаа тогтоогоогүй буюу болзол тавиагүй, үүргийн шинж чанараас шалтгаалан түүнийг тодорхойлох боломжгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг хэдийд ч шаардах эрхтэй, үүрэг гүйцэтгэгч нэн даруй гүйцэтгэх үүрэгтэй байна", 219 дүгээр зүйлийн 219.1-д "Үүрэг гүйцэтгэгч хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч учирсан хохирлоо арилгуулахаар шаардах эрхтэй", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "хүлээн зөвшөөрөгдөхүйц байх", 4.1.3-т "үр ашигтай байх", 4.1.6-д "сахилга баттай байх", 4.1.7-д "бодитой байх", 4.1.9-д "хариуцлагатай байх", 4.2.1-т "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 4.2.2-т "хэмнэлтийн горим нь иргэд, олон нийтийн ашиг сонирхолд нийцэж, тэдний дэмжлэгийг хүлээхүйц түвшинд тодорхойлогдсон байх", 4.2.3-т "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Авлага барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, хангалттай нотлох баримтгүйгээс үр ашиггүй зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 4: Дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ, эрсдэлийн удирдлагын хэлтсээс 19 асуудлыг хянаж, зөвлөмжийг холбогдох газар, хэлтэст хүргүүлсэн боловч зөвхөн 3 асуудлын зөвлөмжийн биелэлт 73-76 хувьтай гэж дүгнэсэн. Үүнээс 16 асуудалд хамаарах зөвлөмжийн хэрэгжилтийн мэдээг гаргаагүй, дотоод хяналтаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, хариу арга хэмжээ авч мөрдөж ажилладаггүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-д "дотоод аудит" гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг", 69.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Дотоод хяналтын үйл ажиллагааны үр дүнд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, байгууллагын дүрэм, батлагдсан журмын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 5: Тайлант онд Сангийн яаманд худалдан авах ажиллагаатай холбоотой 9 гомдол ирүүлснээс 6 нь оролцогчийн гомдол үндэслэлтэй буюу захиалагчийн гаргасан шийдвэр буруу гэж үзэн дахин хянан үзэх шийдвэр ирүүлсэн бөгөөд тендер зохион байгуулалтын явц процессын алдаатай, үнэлгээний хороо холбогдох хууль, журмын дагуу ажиллаагүй, түүнд тавих захиалагчийн хяналт сул байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална", 48.2.3-т "үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавих", 48.2.9-д "энэ хуулийн 54.6-д заасан гүйцэтгэгчийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, түүнд тавих хяналт хангалтгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 6: Түүврээр "Гөлтгөнө" нийлүүлэх 5,311.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 багц нээлттэй тендер шалгаруулалтын баримт бичигт хяналт хийхэд тендерийн баримт бичгийг хуульд заасны дагуу архивлаагүй, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл үүссэн тохиолдолд журмын дагуу мэдүүлэх гэж заасан байтал үнэлгээний хорооны гишүүн бүр маягтаар мэдүүлсэн, үнэлгээний хороо тендерийг үнэлэхдээ 18 хоногийн дараа хуралдаж, шалгаруулсан, батлагдсан маягтын дагуу үнэлгээг хийгээгүй, үнэлгээний хорооны хурлын ирц 60 хувьтай оролцсон, Багц 1-д тээврийн хэрэгслийн шаардлага хангаагүй оролцогчийг шалгаруулсан гэх мэт зөрчил илэрсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т "Үнэлгээний хороо тендер нээсэн өдөр тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг эхлүүлнэ", Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаал "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар", А/254 дүгээр тушаал "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам"-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, түүнд тавих хяналт хангалтгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 7: Гүйцэтгэлийн баталгаа шаардах 5 төсөл арга хэмжээний худалдан авалтад шалгарсан оролцогчид 99.9 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг байршуулаагүй байхад гэрээ байгуулсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Гүйцэтгэлийн баталгаа гаргуулан аваагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 8: Хөгжлийн банкны барьцаанд байгаа Хөтөл ХХК-ийн эзэмшлийн хэвийн ажиллагаатай байсан 15 тээврийн хэрэгслийг 2021 онд Цемент шохой ХХК-ийн ажлын талбарт хадгалуулж байгаа бөгөөд хөрөнгө хадгалуулах талаар гэрээ байгуулаагүй байна. Эдгээр тээврийн хэрэгслээс 2 тээврийн хэрэгслийг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд тээврийн хэрэгслүүдэд биет шалгалт хийхэд 5 тээврийн хэрэгсэл нь бүрэн харагдаж байгаа боловч моралын элэгдэлд орсон, үлдсэн 8 тээврийн хэрэгсэл нь бүрэн бүтэн бус, зарим сэлбэг хэрэгсэл байхгүй, тоногдсон, ашиглах боломжгүй болсон байна.

Энэ нь Иргэний тухай хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-т “Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ”, 208 дугаар зүйлийн 208.1-т “Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ”, 208.2-т “Үүрэг гүйцэтгэх хугацаа тогтоогоогүй буюу болзол тавиагүй, үүргийн шинж чанараас шалтгаалан түүнийг тодорхойлох боломжгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг хэдийд ч шаардах эрхтэй, үүрэг гүйцэтгэгч нэн даруй гүйцэтгэх үүрэгтэй байна”, 219 дүгээр зүйлийн 219.1-т “Үүрэг гүйцэтгэгч хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч учирсан хохирлоо арилгуулахаар шаардах эрхтэй” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Хөгжлийн банкны эзэмшлийн хөрөнгийг хүлээлгэж өгөх зөвлөмж өглөө.

Илрүүлэлт 9: Цемент шохой ХХК болон Гриндинг процесс ХХК-ийн хооронд 2019 оны 19/13 дугаартай “Хөрөнгө хадгалуулах” гэрээгээр 200/тонн цаг хүчин чадалтай тээрмийн тоног төхөөрөмж болох 45 хуудас бүхий жагсаалттай хөрөнгийг хадгалуулсан боловч эдгээр хөрөнгийг бүртгэн, эмх цэгцтэй хадгалаагүй, бүрэн бүтэн байгаа эсэх нь тодорхойгүй, хяналт хангалтгүй байгаагаас хөрөнгө дутагдах, алдагдах эрсдэлтэй байна.

Энэ нь Гэрээний Дөрөв. 4.1.4-т “Хадгалагч нь харуул хамгаалалт бүхий хашаа, агуулахад тоног төхөөрөмжийн хадгалж хүний идэвхтэй үйлдэл бүхий гаднын нөлөөнөөс хамгаалах үндсэн үүрэгтэй” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Гэрээнд заасан хөрөнгүүдийг эзэмшигч байгууллагад хүлээлгэн өгч, гэрээ дүгнэсэн актаар баталгаажуулах зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалттай, бусад нийцлийн асуудлууд нь зарим холбогдох хуулийн заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, санхүүгийн тайлангийн бүх дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 138,556.8 сая төгрөгийн 5 алдааг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 21,757.3 сая төгрөгийн 6 зөрчил илэрснээс зөрчлийг арилгах, таслан зогсоох 21,757.3 сая төгрөгийн 5 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгснөөс 4 албан шаардлага, 1 зөвлөмж хэрэгжээгүй хэрэгжилт 16.6 хувьтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	5	21,757,266.7	1	56,744.5	20.0
Зөвлөмж	1	-			-
Нийт дүн	6	21,757,266.7	1	56,744.5	16.6

Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмж хэрэгжээгүй дараах зөрчлүүдэд дараагийн шийдлийг сонгосон. Үүнд:

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлээгүй зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага;
2. Найдваргүй авлагын нөөц байгуулах журам боловсруулан мөрдөж, ажиллах өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд албан шаардлага;
3. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага;
4. Өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага;
5. Гүйцэтгэх захирлын буруутай шийдвэрээр 7 ажилтны ажилгүй байсан хугацааны цалинг байгууллагаас төлж, буруутай шийдвэр гаргасан этгээдээс авах авлага үүсгээгүй зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр тус тус шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэх, дээд шатны байгууллагын аудитаар анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд:

- Тайлант онд тээврийн хэрэгслийн биет тооллого хэрэгжүүлсэн бол 2026 онд газар болон үл хөдлөх хөрөнгийг эрсдэлтэй гэж үзсэн;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланг холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв тооцоолж, тайлагнаагүй байх, татвар төлөхөөс зайлсхийсэн, татварын өрийн үлдэглийг зөрүүтэй тайлагнасан байх эрсдэлтэй гэж үзсэн тул анхаарал хандуудах асуудлаар авч үзсэн.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 48,023.4 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 738.7 сая төгрөгийн алдааг залруулж, 47,284.7 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

- Орлогын дэлгэрэнгүй тайланд бусад орлогын дүн болон тайлан оны алдагдлын дүнг 628.2 сая төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Найдваргүй авлагын нөөц тооцох суурь болон хувь хэмжээг бодит байдлаас зөрүүтэй тогтоосон буюу санхүүгийн тайланд тусгагдсан 67,905.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлээс 51,269.8 сая төгрөгийг найдваргүй авлагын нөөцөд тооцож бүртгэсний 14,547.7 сая төгрөгийн нөөц үүсгэж бусад авлагыг хасах 14.3 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнасан;
- Татварын өр төлбөрийн дансны үлдэгдлийг 96.1 сая төгрөгөөр дутуу тайлагнасан;

Залруулаагүй алдаа:

- Санхүүгийн тайланд хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 47,284.7 сая төгрөг бүртгэлтэй байхад үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд тусгагдаагүй дахин үнэлгээний нэмэгдлүүд нь аль хөрөнгөд хамаарах, үнэн зөв бүртгэгдсэн эсэх нь тодорхойгүйд зөвлөмж өглөө.

Аудитаар нийт 511,041.8 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 48.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 109,231.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 401,762.4 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 558,326.5 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 557,603.6 сая төгрөгөөр давсан тул Сөрөг дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Ээлжийн амралттай байх хугацаанд ажлын шаардлагаар 15 ажилтныг дуудаж ажиллуулснаар 10.0 сая төгрөгийн цалинг ээлжийн амралтын олговортой давхардуулан олгосон. Мөн сахилгын шийтгэлтэй 9 ажилтанд 3.9 сая төгрөгийн бүтээлийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т “Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно”, Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн “Журам шинэчлэн баталж, цалин хөлс нэмэх тухай” А/123 тоот тушаалын 8 дугаар зүйлийн 8.5-д “Бүтээлийн урамшууллыг дараах тохиолдолд олгохгүй”, 8.5.2-т “гүйцэтгэх захирлын тушаалаар сахилгын шийтгэл тооцсон” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон 13.9 сая төгрөгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Тушаалаар нэр бүхий 13 ажилтанд олгох нэмэгдлийг бодогдсон цалингаас бус үндсэн цалингаас тооцсоноос 0.9 сая төгрөгийг илүү олгосон. Мөн 1 ажилтаны 5 хоногийн цалинтай чөлөөг давхардуулан 0.4 сая төгрөгийг тус тус илүү бодож олгосон байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон 1.3 сая төгрөгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Мэргэшсэн инженерийн үнэмлэх, нотлох баримтгүй 8 ажилтанд 6.5 сая төгрөгийн мэргэшсэн инженерийн нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Цалин хөлсний журмын 4 дүгээр зүйлийн 4.6.1-т "Ажлын байрны тодорхойлолтод заасан мэргэжлээр ажиллаж байгаа мэргэшсэн ажилтанд үндсэн цалингийн 5.0 хувь, зөвлөх мэргэжилтэнд үндсэн цалингийн 10.0 хувиар мэргэшлийн зэргийн нэмэгдлийг сар бүр олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон 6.5 сая төгрөгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4. Хувь хүнд шилжүүлсэн 22-45 СЭҮ улсын дугаартай “Хьюндай киа мохавэ” маркийн тээврийн хэрэгслийн 2023-2025 онуудын тээврийн хэрэгслийн албан татвар 0.2 сая төгрөгийг байгууллагаас төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хувь хүний хөрөнгийн татварт төлсөн 0.2 сая төгрөгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5. Бараа материалын үлдэгдлээс түүвэрлэн 7 агуулахад хяналтын тооллого хийхэд 22 нэр төрлийн 758 ширхэг 26.2 сая төгрөгийн бараа материал бодитоор оршин байхгүй байна. Бараа материалын хөрөнгийн хадгалалт хамгаалалт, агуулахын эмх цэгц хангалтгүй, 24 агуулахыг 11 нярав хариуцдагаас ашиглалтгүй барааны хуримтлал үүсэх эрсдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 4-т "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай этгээдээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутагдсан хөрөнгийн 26.2 сая төгрөгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Авлагын товчоо тайланд тусгагдсан 176 харилцагч байгууллагын 7,892.5 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил давтагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого

хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй бараа материал хариуцсан нягтлан бодогчид хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

2. Гүйцэтгэх захирлын буруутай шийдвэрээр 7 ажилтны ажилгүй байсан хугацааны цалин болох 315.6 сая төгрөгийг шүүхийн шийдвэрийн дагуу байгууллагаас төлж, буруу шийдвэр гаргасан этгээдээс авах авлага үүсгээгүй зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн буюу компанид хамааралгүй зардлыг бүртгэж, ашгийг бууруулсан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.9-д заасны дагуу "энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", 103.2-д "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар хохирол нөхөн төлүүлэх арга хэмжээг авч, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3. Өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд өглөгийн товчоо тайланд тусгагдсан 574 харилцагчтай холбоотой 20,909.7 сая төгрөгийн өр, 16,372.6 сая төгрөгийн зээлийн хүүгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй өр төлбөр хариуцсан нягтлан бодогчид хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

4. Бараа материалын журналд үлдэгдэлтэй байгаа насжилт өндөртэй 3046 нэрийн 1,027,173 ширхэг 10,013.7 сая төгрөгийн хэрэгцээнээс илүү барааг худалдан авч нөөцөлсөн байна. Мөн насжилт өндөртэй бараанд үнэ цэнийн бууралт тооцоогүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хэрэгцээнээс илүү бараа материал худалдан авч нөөцөлдөг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5. Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 3 орон сууцны байранд удирдлагууд оршин суудаг боловч түрээсийн гэрээ байгуулаагүй байна. Мөн түрээсийн гэрээ байгуулан ажилчид байрлаж байгаа нийт 6 орон сууцыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т “Төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийг санхүүгийн тайланд бүртгээгүй, түрээсийн гэрээ байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

6. Аудитын явцад тээврийн хэрэгслийн данснаас түүвэрлэн 95 тээврийн хэрэгслийг хамруулан хяналтын тооллого хийхэд, 22 тээврийн хэрэгсэл эвдрэлтэй, ашиглалтгүй, 25 тээврийн хэрэгсэл тоногдсон, 2 тээврийн хэрэгсэл осолд орж ашиглах боломжгүй болсон, 7 тээврийн хэрэгсэл биетээр оршин байхгүй зэрэг нийт 4,648.5 сая төгрөгийн ашиглалтгүй 56 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-д “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ашиглах боломжгүй болсон, биетээр байхгүй тээврийг хэрэгслийг дээд шатны байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх албан шаардлага хүргүүлэв.

7. Үндсэн хөрөнгийн тооллогод ажиглалт хийхэд үйлдвэр, хэлтсүүдийн удирдлагуудад хөрөнгийг хариуцуулсан боловч эд хариуцагчийн карт байхгүй, хариуцаж байгаа хөрөнгөө мэдэхгүй, танихгүй, код өгч дугаарлаагүй зэрэг хөрөнгийн ашиглалт хадгалалтад тавих хяналт сул, хөрөнгө дутагдах, солигдох эрсдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1-д энгийн хялбар, чанга хатуу байх”, 4.1.6-д “сахилга баттай байх”, 4.1.9-д “хариуцлагатай байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т “Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй: 1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эд хариуцагчийн карт хөтлөөгүй, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажилладаггүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

8. Өмнөх оны аудитаар өгсөн найдваргүй авлагын нөөц байгуулах журмыг шинэчлэн боловсруулж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, найдваргүй авлагын нөөц тооцох суурь болон хувь хэмжээг бодит байдалд нийцүүлэн тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд тусгагдсан 65,981.1 сая төгрөгийн авлагын үлдэгдэлд 35,746.1 сая төгрөгийг найдваргүй авлагын нөөц байгуулж, авлагын цэвэр үлдэгдэл 30,235.1 сая төгрөг хүртэл буурсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-д “үнэн зөв байх”, 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19.1-т “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

9. Ажиллагсадтай холбоотой авлагын данстад цалингийн урьдчилгааг өндөр хэмжээтэй /5.0-15.0 сая төгрөгөөр/ олгосноос 40 иргэний 325.2 сая төгрөгийн төлбөр барагдуулах хугацаа хэтэрсэн, мөн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажиллагсад өндөр дүнтэй цалингийн урьдчилгаа олгодог, үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

10. Тайлант онд гэрээний үнийн дүнгээс хэтрүүлэн 16 харилцагчаас 5,980.7 сая төгрөгийн худалдан авалт хийсэн, 10 харилцагчаас 5,135.6 сая төгрөгийн худалдан авалтыг шууд гэрээ байгуулж гүйцэтгэн, нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргыг хэрэглээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 32 дугаар зүйлийн 32.1-д "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний дүнгээс хэтрүүлэн худалдан авалт хийсэн, нээлттэй тендер сонгон шалгаруулахгүйгээр шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

11. Тайлант онд 18 харилцагчдад 1,375.9 сая төгрөгийн борлуулалтын орлогын төлбөрийн баримтыг харилцагчдад шивж өгөөгүйгээс тус орлогыг татварт тайлагнаагүй буюу 137.6 сая төгрөгийн НӨАТ-ын татвар төлөхөөс зайлсхийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Борлуулалтын орлогыг үнэн зөв тодорхойлоогүй, НӨАТ төлөхөөс зайлсхийсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

12. Тайлант онд 32 харилцагчдад 514.9 сая төгрөгийн борлуулалтын орлогын төлбөрийн баримтыг үндэслэх баримтгүй шивж, борлуулалтын орлогыг өсгөсөн, худалдан авагч байгууллага нь 51.5 сая төгрөгийн НӨАТ-ын худалдан авалтын буцаалтыг үндэслэлгүйгээр хасуулсан, орлогыг санаатай нуун дарагдуулсан, гэмт хэргийн шинжтэй зөрчил илэрсэн.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;", Татварын ерөнхий хуулийн 28.5 "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Борлуулалтын орлогын төлбөрийн баримтыг үндэслэх баримтгүй шивж, борлуулалтын орлогыг өсгөсөн санаатай үйлдэл гаргасан авлага, борлуулалт хариуцсан нягтлан бодогчид хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

1. Цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Сахилгын шийтгэлийн суутгалыг үндсэн цалингаас бус гарт олгох цалингаас суутгаснаас шалтгаалан 81 хүний 56.3 сая төгрөгөөр цалингийн зардал өсгөж тооцогдсон, үүнээс 20 ажилтныг түүвэрлэн бодолтыг шалгахад нийгмийн даатгалын шийтгэлийн суутгал 3.4 сая төгрөг, ХХОАТ-ыг 0.9 сая төгрөгөөр илүү төлсөн, ажилтны гарт олгох цалинг 5.2 сая төгрөгөөр дутуу тооцсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалин хөлсийг үнэн зөв тооцоолж олгох

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой нийт 3196 нэр төрлийн 12,876.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үнэ, хугацааг шинэчлэн тогтоогоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ", Компанийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.3.1.8-д "Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн зах зээлийн үнийг тогтоох, данснаас хасах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид ашиглах боломжтой хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож, ашиглалтыг хугацааг үнэн зөв тооцоолох

Илрүүлэлт 2: Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд 454 ширхэг 5,019.5 сая төгрөгийн хөрөнгийг ангилал, тоо хэмжээ зөрүүтэй, 262 нэр төрлийн 9,668.8 сая төгрөгийн хөрөнгийн нэршлийг монгол хэлээр тусгаагүй, 5 ширхэг хөрөнгийн үнийг 0 төгрөгөөр бүртгэсэн нь хөрөнгө алга болох, солигдох эрсдэлтэй, хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд монгол хэлээр, тоо ширхэг, үнийн дүнг үнэн зөв бүртгэх

3. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Худалдан авалттай холбоотой гэрээний үнийн дүнгийн 5%-тай тэнцэх чанарын баталгааны өр төлбөрийг тусад нь өр төлбөрийн данс үүсгэн бүртгээгүйгээс нэмэгдсэн болон чөлөөлсөн гүйлгээг тулган баталгаажуулалт хийх боломжгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааны чанарын баталгааны өр төлбөрийн дансыг тусад нь данс үүсгэн бүртгэж, хяналт тавьж ажиллах

Илрүүлэлт 2: Авлигатай тэмцэх газрын захиалгаар 2022 онд хийгдсэн Аудитын дүгнэлтэд Бэйзмент ХХК-ийн хөрөнгө оруулалтыг 114,636,117.82 ам доллар буюу 157,525.5 сая төгрөг, төсөлд зарцуулсан зардлыг 33,602.9 сая төгрөг, нийт 190,796.4 сая төгрөгөөр баталгаажуулсан байна. Гэтэл компанийн урт хугацаат өр дансанд Хөгжлийн банканд төлөх өрийг 276,158.8 сая төгрөг, Худалдаа хөгжлийн банканд төлөх зээлийн өрийг 41,916.8 сая төгрөгөөр тайлагнаж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаагаас үзэхэд Цемент шохой ХХК-ийн хөрөнгө оруулалтын хэмжээ бодитой бүртгэгдээгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Компанийн хөрөнгө оруулалтын үнэн зөв тогтоож, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах

Илрүүлэлт 3: Өмнөх тайлант хугацаанд 2,213.4 сая төгрөгийн байгаль орчны нөхөн сэргээлтийн нөөц үүсгэн бүртгэхдээ уул уурхайн хөрөнгийн өртөгт капиталжуулан бүртгэхийг зардлаар хүлээн зөвшөөрч буруу бүртгэсэн. Үүнтэй холбоотойгоор дотоод аудитын зөвлөмжийн дагуу тайлант онд тус нөөц санг 962.9 сая төгрөгөөр бууруулан бүртгэхдээ хуримтлагдсан ашгийг нэмэгдүүлж буруу бүртгэсэн байна.

Энэ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т “байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх, тогтвортой ашиглах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тодорхой асуудлаар төрийн захиргааны бусад төв байгууллага, аймаг, нийслэлийн хэмжээнд мөрдөх шийдвэр, дүрэм, журам баталж биелэлтийг хангуулах”, 15.1.3-т “байгаль орчныг хамгаалах, түүний баялгийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар салбар дундын болон бүс нутаг хоорондын удирдлага, бодлогын төлөвлөлт, зохицуулалтыг хариуцаж, байгаль орчны чадавхын хэм хэмжээ, стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах буюу төрийн захиргааны холбогдох төв байгууллагатай хамтран баталж, биелэлтийг зохион байгуулах, экологи-эдийн засгийн үнэлгээ тооцох аргачлалыг батлах”, Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 1.8-д “байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нөөц санг үүсгэхдээ холбогдох стандарт, дүрэм, журмыг баримтлан үнэн зөв бүртгэх

4. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Авлагын дансанд бүртгэх 78.4 сая төгрөгийн байгаль орчны нөхөн сэргэлтийн барьцаа төлбөрийг урьдчилж төлсөн зардал дансанд тайлагнасан. Тус үлдэгдэл нь 2014 оноос хойш үүссэн боловч тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлт хийгээгүйгээс барьцааны хөрөнгийг буцаан аваагүй байна.

Энэ нь Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 1.8-д "байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамтай тооцоо нийлж, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулах

5. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Борлуулалтын авлагад бартераар хүлээн авсан 546.2 сая төгрөгийн цамхагт краныг борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөд бүртгэсэн боловч борлуулагдаагүй удсан, үйл ажиллагаанд ашигладаггүй, биет шалгалт хийхэд ихээхэн хуучин, ажиллах боломжтой эсэх нь тодорхойгүй үнэ цэнэ буурсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйл ажиллагаанд хэрэгцээгүй, борлуулагдах эсэх нь тодорхойгүй хөрөнгөөр авлагыг хааж, үр ашиггүй зардал гаргахгүй байх

6. Орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Борлуулалтын орлогыг стандартын дагуу данс бүртгэлд тусгасан эсэхийг хянахад нийт 40,884.7 сая төгрөгийн орлогыг бүртгэхдээ борлуулалтын авлага дансанд тооцоо үүсгэж бүртгээгүй, бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өглөг, цалингийн өглөг, мөн бараа материалын данснаас орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн зэрэг буруу бүртгэсэн байна. Мөн бартерын борлуулалтыг их хэмжээгээр хийснээс мөнгөн хөрөнгийн эргэлт буурсан, бараа материалыг өртгөөс нь бага үнээр борлуулсан байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө", 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийг аккрузал сууриар хөтлөх

Илрүүлэлт 2: Өмнөх он болон тайлант онуудад 36 харилцагчид барьцааны болон гэрээт борлуулагчийн гэрээг үндэслэн өмнөх худалдан авалтын төлбөрийг барагдуулаагүй байхад нэмж их хэмжээгээр цемент олгосноор, нийт 12,343.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэл хуримтлагдсан нь компанийн төлбөрийн чадварт сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй тул Авлигатай тэмцэх газарт шалгагдаж байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "энгийн хялбар, чанга хатуу байх", 4.1.2-т "хүлээн зөвшөөрөгдөхүйц байх", 4.1.3-т "үр ашигтай байх", 4.1.4-т "хүрсэн түвшнээс бууруулахгүй байх", 4.1.5-д "ил тод байх", 4.1.6-д "сахилга баттай байх", 4.1.7-д "бодитой байх", 4.1.8-д "өөрчлөлт, шинэчлэлийг дэмжих", 4.1.9-д "хариуцлагатай байх", 4.1.10-т "тасралтгүй байх", 4.2.1-т "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 4.2.2-т "хэмнэлтийн горим нь иргэд, олон нийтийн ашиг сонирхолд нийцэж, тэдний дэмжлэгийг хүлээхүйц түвшинд тодорхойлогдсон байх", 4.2.3-т "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Орлогын дэлгэрэнгүй тайланд бусад орлогын дүн болон тайлан оны алдагдлын дүнг 628.2 сая төгрөгөөр дутуу тайлагнасан	1	628,220.7	1	628,220.7			1	628,220.7				
2	Найдваргүй авлагын нөөц тооцох суурь болон хувь хэмжээг бодит байдлаас зөрүүтэй тогтоосон буюу санхүүгийн тайланд тусгагдсан 67,905.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлээс 51,269.8 сая төгрөгийг найдваргүй авлагын нөөцөд тооцож бүртгэсний 14,547.7 сая төгрөгийн нөөц үүсгэж бусад авлагыг хасах 14.3 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнасан	1	14,339.2			1	14,339.2	1	14,339.2				
3	Татварын өр төлбөрийн дансны үлдэгдлийг 96.1 сая төгрөгөөр дутуу тайлагнасан	1	96,104.8	1	96,104.8			1	96,104.8				
4	Санхүүгийн тайланд хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 47,284.7 сая төгрөг бүртгэлтэй байхад үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд тусгагдаагүй дахин үнэлгээний нэмэгдлүүд нь аль хөрөнгөд хамаарах, үнэн зөв бүртгэгдсэн эсэх нь тодорхойгүй байна.	1	47,284,714.8	1	47,284,714.8					1	47,284,714.8	1	47,284,714.8
Дүн		4	48,023,379.5	3	48,009,040.3	1	14,339.2	3	738,664.7	1	47,284,714.8	1	47,284,714.8

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ээлжийн амралттай байх хугацаанд ажлын шаардлагаар 15 ажилтныг дуудаж ажиллуулснаар 10.0 сая төгрөгийн цалинг ээлжийн амралтын олговортой давхардуулан олгосон. Мөн сахилгын шийтгэлтэй 9 ажилтанд 3.9 сая төгрөгийн бүтээлийн урамшуулал олгосон байна.	1	13,956.7	1	13,956.7								
2	Тушаалаар нэр бүхий 13 ажилтанд олгох нэмэгдлийг бодогдсон цалингаас бус үндсэн цалингаас тооцсоноос 0.9 сая төгрөгийг илүү олгосон. Мөн 1 ажилтны 5 хоногийн цалинтай чөлөөг давхардуулан 0.4 сая төгрөгийг тус тус илүү бодож олгосон байна.	1	1,342.9	1	1,342.9								
3	Мэргэшсэн инженерийн үнэмлэх, нотлох баримтгүй 8 ажилтанд 6.5 сая төгрөгийн мэргэшсэн инженерийн нэмэгдэл олгосон байна.	1	6,519.9	1	6,519.9								
4	Хувь хүнд шилжүүлсэн 22-45 СЭУ улсын дугаартай “Хьюндай киа мохавэ” маркийн тээврийн хэрэгслийн 2023-2025 онуудын тээврийн хэрэгслийн албан татвар 0.2 сая төгрөгийг байгууллагаас төлсөн байна.	1	212.6	1	212.6								

Цемент шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

5	Бараа материалын үлдэгдлээс түүвэрлэн 7 агуулахад хяналтын тооллого хийхэд 22 нэр төрлийн 758 ширхэг 26.2 сая төгрөгийн бараа материал бодитоор оршин байхгүй байна. Бараа материалын хөрөнгийн хадгалалт хамгаалалт, склад агуулахын эмх цэгц хангалтгүй, 24 складыг 11 нярав хариуцдагаас ашиглалтгүй барааны хуримтлал үүсэх эрсдэлтэй байна.	1	26,194.4	1	26,194.4								
6	Авлагын товчоо тайланд тусгагдсан 176 харилцагч байгууллагын 7,892.5 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил давтагдсан байна.	1	7,892,484.3						1	7,892,484.3			
7	Гүйцэтгэх захирлын буруутай шийдвэрээр 7 ажилтны ажилгүй байсан хугацааны цалин болох 315.6 сая төгрөгийг шүүхийн шийдвэрийн дагуу байгууллагаас төлж, буруу шийдвэр гаргасан этгээдээс авах авлага үүсгээгүй зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн буюу компанид хамааралгүй зардлыг бүртгэж, ашгийг бууруулсан.	1	315,650.3		1	315,650.3							
8	Өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд өглөгийн товчоо тайланд тусгагдсан 574 харилцагчтай холбоотой 20,909.7 сая төгрөгийн өр, 16,372.6 сая төгрөгийн зээлийн хүүгийн өр төлбөрийн үлдэгдлийг	1	37,282,285.5						1	37,282,285.5			

Цемент шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.												
9	Бараа материалын журналд үлдэгдэлтэй байгаа насжилт өндөртэй 3046 нэрийн 1,027,173 ширхэг 10,013.7 сая төгрөгийн хэрэгцээнээс илүү барааг худалдан авч нөөцөлсөн байна. Мөн насжилт өндөртэй бараанд үнэ цэнийн бууралт тооцоогүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогод үнэ цэнийн бууралт тооцох талаар тусгаагүй байна.	1	10,013,754.1			1	10,013,754.1						
10	Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 3 орон сууцны байранд удирдлагууд оршин суудаг боловч түрээсийн гэрээ байгуулаагүй байна. Мөн түрээсийн гэрээ байгуулан ажилчид байрлаж байгаа нийт 6 орон сууцыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.	1				1							
11	Аудитын явцад тээврийн хэрэгслийн данснаас түүвэрлэн 95 тээврийн хэрэгслийг хамруулан хяналтын тооллого хийхэд, 22 тээврийн хэрэгсэл эвдрэлтэй, ашиглалтгүй, 25 тээврийн хэрэгсэл тоногдсон, 2 тээврийн хэрэгсэл осолд орж ашиглах боломжгүй болсон, 7 тээврийн хэрэгсэл биетээр оршин байхгүй зэрэг нийт 4,648.5 сая төгрөгийн ашиглалтгүй 56 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна.	1	4,648,555.9			1	4,648,555.9				1	4,648,555.9	
12	Үндсэн хөрөнгийн тооллогод ажиглалт хийхэд үйлдвэр, хэлтсүүдийн удирдлагуудад хөрөнгийг хариуцуулсан боловч эд хариуцагчийн карт байхгүй, хариуцаж	1				1							

Цемент шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	байгаа хөрөнгөө мэдэхгүй, танихгүй, код өгч дугаарлаагүй зэрэг хөрөнгийн ашиглалт хадгалалтад тавих хяналт сул, хөрөнгө дутагдах, солигдох эрсдэлтэй байна.											
13	Өмнөх оны аудитаар өгсөн найдваргүй авлагын нөөц байгуулах журмыг шинэчлэн боловсруулж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, найдваргүй авлагын нөөц тооцох суурь болон хувь хэмжээг бодит байдалд нийцүүлэн тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд тусгагдсан 65,981.1 сая төгрөгийн авлагын үлдэгдэлд 35,746.1 сая төгрөгийг найдваргүй авлагын нөөц байгуулж, авлагын цэвэр үлдэгдэл 30,235.1 сая төгрөг хүртэл буурсан байна.	1	35,746,070.0			1	35,746,070.0					
14	Ажиллагсадтай холбоотой авлагын данстад цалингийн урьдчилгааг өндөр хэмжээтэй /5.0-15.0 сая төгрөгөөр/ олгосноос 40 иргэний 325.2 сая төгрөгийн төлбөр барагдуулах хугацаа хэтэрсэн, мөн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.	1	325,177.4			1	325,177.4					
15	Тайлант онд гэрээний үнийн дүнгээс хэтрүүлэн 16 харилцагчаас 5,980.7 сая төгрөгийн худалдан авалт хийсэн, 10 харилцагчаас 5,135.6 сая төгрөгийн худалдан авалтыг шууд гэрээ байгуулж гүйцэтгэн, нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргыг хэрэглээгүй байна.	1	11,116,374.0			1	11,116,374.0					
16	Тайлант онд 18 харилцагчдад 1,375.9 сая төгрөгийн борлуулалтын орлогын	1	1,375,875.8			1	1,375,875.8					

Цемент шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	төлбөрийн баримтыг харилцагчдад шивж өгөөгүйгээс тус орлогыг татварт тайлагнаагүй буюу 137.6 сая төгрөгийн НӨАТ-ын татвар төлөхөөс зайлсхийсэн байна.											
17	Сахилгын шийтгэлийн суутгалыг үндсэн цалингаас бус гарт олгох цалингаас суутгаснаас шалтгаалан 81 хүний 56.3 сая төгрөгөөр цалингийн зардал өсгөж тооцогдсон, үүнээс 20 ажилтныг түүвэрлэн бодолтыг шалгахад нийгмийн даатгалын шийтгэлийн суутгал 3.4 сая төгрөг, ХХОАТ-ыг 0.9 сая төгрөгөөр илүү төлсөн, ажилтны гарт олгох цалинг 5.2 сая төгрөгөөр дутуу тооцсон байна.	1	56,295.6					1	56,295.6			
18	Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой нийт 3196 нэр төрлийн 12,876.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үнэ, хугацааг шинэчлэн тогтоогоогүй байн	1	12,876,113.0					1	12,876,113.0			
19	Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд 454 ширхэг 5,019.5 сая төгрөгийн хөрөнгийг ангилал, тоо хэмжээ зөрүүтэй, 262 нэр төрлийн 9,668.8 сая төгрөгийн хөрөнгийн нэршлийг монгол хэлээр тусгаагүй, 5 ширхэг хөрөнгийн үнийг 0 төгрөгөөр бүртгэсэн нь хөрөнгө алга болох, солигдох эрсдэлтэй, хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна.	1	14,688,315.0					1	14,688,315.0			
20	Худалдан авалттай холбоотой гэрээний үнийн дүнгийн 5%-тай тэнцэх чанарын баталгааны өр төлбөрийг тусад нь өр төлбөрийн данс үүсгэн	1						1				

Цемент шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	бүртгээгүйгээс нэмэгдсэн болон чөлөөлөгдсөн гүйлгээг тулган баталгаажуулалт хийх боломжгүй байна.											
21	Авлигатай тэмцэх газрын захиалгаар 2022 онд хийгдсэн Аудитын дүгнэлтэд Бэйзмент ХХК-ийн хөрөнгө оруулалтыг 114,636,117.82 ам доллар буюу 157,525.5 сая төгрөг, төсөлд зарцуулсан зардлыг 33,602.9 сая төгрөг, нийт 190,796.4 сая төгрөгөөр баталгаажуулсан байна. Гэтэл компанийн урт хугацаат өр дансанд Хөгжлийн банканд төлөх өрийг 276,158.8 сая төгрөг, Худалдаа хөгжлийн банканд төлөх зээлийн өрийг 41,916.8 сая төгрөгөөр тайлагнаж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаагаас үзэхэд Цемент шохой ХХК-ийн хөрөнгө оруулалтын хэмжээ бодитой бүртгэгдээгүй байх эрсдэлтэй байна.	1	318,075,655.8				1	318,075,655.8				
22	Өмнөх тайлант хугацаанд 2,213.4 сая төгрөгийн байгаль орчны нөхөн сэргээлтийн нөөц үүсгэн бүртгэхдээ уул уурхайн хөрөнгийн өртөгт капиталжуулан бүртгэхийг зардлаар хүлээн зөвшөөрч буруу бүртгэсэн. Үүнтэй холбоотойгоор дотоод аудитын зөвлөмжийн дагуу тайлант онд тус нөөц санг 962.9 сая төгрөгөөр бууруулан бүртгэхдээ хуримтлагдсан ашгийг нэмэгдүүлж буруу бүртгэсэн байна.	1	2,213,391.3				1	2,213,391.3				
23	Авлагын дансанд бүртгэх 78.4 сая төгрөгийн байгаль орчны нөхөн	1	78,399.5				1	78,399.5				

Цемент шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	сэргэлтийн барьцаа төлбөрийг урьдчилж төлсөн зардал дансанд тайлагнасан. Тус үлдэгдэл нь 2014 оноос хойш үүссэн боловч тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлт хийгээгүйгээс барьцааны хөрөнгийг буцаан аваагүй байна.											
24	Борлуулалтын авлагад бартераар хүлээн авсан 546.2 сая төгрөгийн цамхагт краныг борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөд бүртгэсэн боловч борлуулагдаагүй удсан, үйл ажиллагаанд ашигладаггүй, биет шалгалт хийхэд ихээхэн хуучин, ажиллах боломжтой эсэх нь тодорхойгүй үнэ цэнэ буурсан байна.	1	546,192.9					1	546,192.9			
25	Борлуулалтын орлогыг стандартын дагуу данс бүртгэлд тусгасан эсэхийг хянахад нийт 40,884.7 сая төгрөгийн орлогыг бүртгэхдээ борлуулалтын авлага дансанд тооцоо үүсгэж бүртгээгүй, бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өглөг, цалингийн өглөг, мөн бараа материалын данснаас орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн зэрэг буруу бүртгэсэн байна. Мөн бартерын борлуулалтыг их хэмжээгээр хийснээс мөнгөн хөрөнгийн эргэлт буурсан, бараа материалыг өртгөөс нь бага үнээр борлуулсан байна	1	40,884,714.4					1	40,884,714.4			
26	Өмнөх он болон тайлант онуудад 36 харилцагчид барьцааны болон гэрээт борлуулагчийн гэрээг үндэслэн өмнөх	1	12,343,367.3					1	12,343,367.3			

Цемент шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	худалдан авалтын төлбөрийг барагдуулаагүй байхад нэмж их хэмжээгээр цемент олгосноор, нийт 12,343.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэл хуримтлагдсан нь компанийн төлбөрийн чадварт сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй тул Авилгатай тэмцэх газарт шалгагдаж байна.												
27	Тайлант онд 32 харилцагчдад 514.9 сая төгрөгийн борлуулалтын орлогын төлбөрийн баримтыг үндэслэх баримтгүй шивж, борлуултын орлогыг өсгөсөн, худалдан авагч байгууллага нь 51.5 сая төгрөгийн НӨАТ-ын худалдан авалтын буцаалтыг үндэслэлгүйгээр хасуулсан, орлогыг санаатай нуун дарагдуулсан, гэмт хэргийн шинжтэй зөрчил илэрсэн.	1	514,889.1			1	514,889.1			1	514,889.1	1	514,889.1
	Дүн	27	511,041,787.7	5	48,226.5	9	63,541,457.5	10	401,762,444.8	3	45,689,658.9	2	5,163,445.0

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй шилэн дансны цахим хуудсанд 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 удаагийн 105.0 сая төгрөгийн орлого, 3 удаагийн 150.0 сая төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээллээгүй, 17 удаагийн 3,508.4 сая төгрөгийн орлого, 42 удаагийн 3,236.1 сая төгрөгийн зарлагын гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн байна.	1	6,999,558.9			1	6,999,558.9		
Дүн		1	6,999,558.9	0	0.0	1	6,999,558.9	0	0.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
1	Тус компанийн захиргааны бүтэц хэт олон орон тоотой байгаагаас удирдлагын тогтмол зардал өндөр гарч, бүтээгдэхүүний өртөг, компанийн ашигт ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна. Мөн санхүүгийн албаны бүтэц зохион байгуулалт оновчгүй, ажлын ачаалал тэнцвэргүй, зарим ажлын зохион байгуулалт давхардсан олон хүний оролцоотой байна. Тухайлбал цалин хөлсийг бодоход төлөвлөлтийн албаны 4 эдийн засагч хийдэг, суутгах тооцооллыг санхүүгийн албаны нягтлан бодогч хариуцдаг зэргээр олон хүний оролцоо нь хяналт алдагдах, ажил цалгардах зэргээс шалтгаалан цалин хөлс буруу бодох эрсдэл гарч байна.	1		1					
2	Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тайланг зөрүүтэй гаргасан, хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөртэй холбоотой зөрүүгийн тайлангийн тооцоолол хийгээгүй, санхүүгийн тайлан болон татварын тодорхойлолтоор татварын өрийн үлдэгдэл зөрүүтэй зэрэг татварын багц хуулийг мөрдөж ажиллаагүй байна.	1		1					
3	Хуулийн хэлтэс нь 90 харилцагчтай холбоотой 44,212.6 сая төгрөгийн авлагыг барагдуулах ажлыг хариуцаж хийхээс, тайлант онд 0.1 хувь буюу	1		1					

Цемент шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	49.3 сая төгрөгийн авлага барагдсан, 38.7 сая төгрөгийн авлагын шүүхийн шийдвэр гарсан бөгөөд авлагыг барагдуулах хангалттай арга хэмжээ аваагүй байна. Мөн Шүүхэд хүргүүлсэн 17 нэхэмжлэл холбогдох баримт материал хангалтгүйгээс буцаж, тэмдэгтийн хураамжид 9.8 сая төгрөгийг төлж, үр ашиггүй зардал гаргасан байна. Компанийн Удирдах зөвлөлөөс хүчин төгөлдөр мөрдөж байгаа дүрэм, журмуудын хэрэгжилтийг хянах талаар үүрэг өгсөн нь хэрэгжээгүй, тус компанийн хэмжээнд нийт хэдэн дүрэм, журам мөрдөж байгаа нь тодорхой бус байна.							
4	Дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ, эрсдэлийн удирдлагын хэлтсээс 19 асуудлыг хянаж, зөвлөмжийг холбогдох газар, хэлтэст хүргүүлсэн боловч зөвхөн 3 асуудлын зөвлөмжийн биелэлт 73-76 хувьтай гэж дүгнэсэн. Үүнээс 16 асуудалд хамаарах зөвлөмжийн хэрэгжилтийн мэдээг гаргаагүй, дотоод хяналтаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, хариу арга хэмжээ авч мөрдөж ажилладаггүй байна.	1		1				
5	Тайлант онд Сангийн яаманд худалдан авах ажиллагаатай холбоотой 9 гомдол ирүүлснээс 6 нь оролцогчийн гомдол үндэслэлтэй буюу захиалагчийн гаргасан шийдвэр буруу гэж үзэн дахин хянан үзэх шийдвэр ирүүлсэн бөгөөд тендер зохион байгуулалтын явц процессын алдаатай, үнэлгээний хороо холбогдох хууль, журмын дагуу ажиллаагүй, түүнд тавих захиалагчийн хяналт сул байна.	1		1				
6	Түүврээр "Гөлтгөнө" нийлүүлэх 5,311.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 багц нээлттэй тендер шалгаруулалтын баримт бичигт хяналт хийхэд тендерийн баримт бичгийг хуульд заасны дагуу архивлаагүй, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл үүссэн тохиолдолд журмын дагуу мэдүүлэх гэж заасан байтал үнэлгээний хорооны гишүүн бүр маягтаар мэдүүлсэн, үнэлгээний хороо тендерийг үнэлэхдээ 18 хоногийн дараа хуралдаж, шалгаруулсан, батлагдсан маягтын дагуу үнэлгээг хийгээгүй, үнэлгээний хорооны хурлын ирц 60 хувьтай оролцсон, Багц 1-д тээврийн хэрэгслийн шаардлага хангаагүй оролцогчийг шалгаруулсан гэх мэт зөрчил илэрсэн.	1	5,311,680.0	1	5,311,680.0			
7	Гүйцэтгэлийн баталгаа шаардах 5 төсөл арга хэмжээний худалдан авалтад шалгарсан оролцогчид 99.9 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг байршуулаагүй байхад гэрээ байгуулсан.	1	99,943.7	1	99,943.7			
8	Хөгжлийн банкны барьцаанд байгаа Хөтөл ХХК-ийн эзэмшлийн хэвийн ажиллагаатай байсан 15 тээврийн хэрэгслийг 2021 онд Цемент шохой ХХК-ийн ажлын талбарт хадгалуулж байгаа бөгөөд хөрөнгө хадгалуулах талаар гэрээ байгуулаагүй байна. Эдгээр тээврийн хэрэгслээс 2 тээврийн	1						1

Цемент шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	хэрэгслийг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд тээврийн хэрэгслүүдэд биет шалгалт хийхэд 5 тээврийн хэрэгсэл нь бүрэн харагдаж байгаа боловч моралын элэгдэлд орсон, үлдсэн 8 тээврийн хэрэгсэл нь бүрэн бүтэн бус, зарим сэлбэг хэрэгсэл байхгүй, тоногдсон, ашиглах боломжгүй болсон байна.								
9	Цемент шохой ХХК болон Гриндинг процесс ХХК-ийн хооронд 2019 оны 19/13 дугаартай "Хөрөнгө хадгалуулах" гэрээгээр 200/тонн цаг хүчин чадалтай тээрмийн тоног төхөөрөмж болох 45 хуудас бүхий жагсаалттай хөрөнгийг хадгалуулсан боловч эдгээр хөрөнгийг бүртгэн, эмх цэгцтэй хадгалаагүй, бүрэн бүтэн байгаа эсэх нь тодорхойгүй, хяналт хангалтгүй байгаагаас хөрөнгө дутагдах, алдагдах эрсдэлтэй байна.	1						1	
	Дүн	9	5,411,623.7	7	5,411,623.7	0	0.0	2	0.0
	Нийт дүн	10	12,411,182.6	7	5,411,623.7	1	6,999,558.9	2	0.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 178/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/85/НА-СТА-ТОХТ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мэргэшсэн инженерийн үнэмлэх, нотлох баримтгүй 8 ажилтанд 6,519,885.00 /зургаан сая таван зуун арван есөн мянга найман зуун наян таван/ төгрөгийн мэргэшсэн инженерийн нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Цалин хөлсний журмын 4 дүгээр зүйлийн 4.6.1-т "Ажлын байрны тодорхойлолтод заасан мэргэжлээр ажиллаж байгаа мэргэшсэн ажилтанд үндсэн цалингийн 5%, зөвлөх мэргэжилтэнд үндсэн цалингийн 10%-иар мэргэшлийн зэргийн нэмэгдлийг сар бүр олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү тооцож олгосон 6,519,885.00 /зургаан сая таван зуун арван есөн мянга найман зуун наян таван/ төгрөгийг Санхүү, удирдлагын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Б.Нямбаяраар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/- т хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо АТН-аасой тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-261230

9025109
9025081411

Z:\Akt\2026\0316\SAG-29.Docx

1526200221



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 179/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/85/НА-СТА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын үлдэгдлээс түүвэрлэн 7 агуулахад хяналтын тооллого хийхэд 22 нэр төрлийн 758 ширхэг 26,194,404.00 /хорин зургаан сая нэг зуун ерэн дөрвөн мянга дөрвөн зуун дөрвөн/ төгрөгийн бараа материал бодитоор оршин байхгүй байна. Бараа материалын хөрөнгийн хадгалалт хамгаалалт, агуулахын эмх цэгц хангалтгүй, 24 агуулахыг 11 нярав хариуцдагаас ашиглалтгүй барааны хуримтлал үүсэх эрсдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна.", 73 дугаар зүйлийн 4-т "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай этгээдээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.7-д "төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дутагдсан хөрөнгийн 26,194,404.00 /хорин зургаан сая нэг зуун ерэн дөрвөн мянга дөрвөн зуун дөрвөн/төгрөгийг Санхүү, бүртгэл, тайлагналын хэлтсийн дарга Б.Алтанхундагаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/-т хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 180/АДИСО185

Улаанбаатар хот

САГ-2026/85/НА -СТА -ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ээлжийн амралттай байх хугацаанд ажлын шаардлагаар 15 ажилтныг дуудаж ажиллуулснаар 10,028,300.00 /арван сая хорин найман мянга гурван зуун/ төгрөгийн цалинг ээлжийн амралтын олговортой давхардуулан олгосон. Мөн сахилгын шийтгэлтэй 9 ажилтанд 3,928,400.00 /гурван сая есөн зуун хорин найман мянга дөрвөн зуун/ төгрөгийн бүтээлийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-д "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно", Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн "Журам шинэчлэн баталж, цалин хөлс нэмэх тухай" А/123 тоот тушаалын 8 дугаар зүйлийн 8.5-д "Бүтээлийн урамшууллыг дараах тохиолдолд олгохгүй", 8.5.2-т "гүйцэтгэх захирлын тушаалаар сахилгын шийтгэл тооцсон" гэж заасантай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү тооцож олгосон 13,956,700.00 /арван гурван сая есөн зуун тавин зургаан мянга долоон зуун/ төгрөгийг Санхүү, бүртгэл, тайлагналын хэлтсийн дарга Б.Алтанхундагаар Нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/-т хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 181/АО150185

Улаанбаатар хот

САГ-2026/85/НА-СТА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тушаалаар нэр бүхий 13 ажилтанд олгох нэмэгдлийг бодогдсон цалингаас бус үндсэн цалингаас тооцсоноос 967,400.00 /есөн зуун жаран долоон мянга дөрвөн зуун/төгрөгийг илүү олгосон. Мөн 1 ажилтны 5 хоногийн цалинтай чөлөөг давхардуулан 375,500.00 /гурван зуун далан таван мянга таван зуун/төгрөгийг тус тус илүү бодож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь**.

- Илүү тооцож олгосон 1,342,900.00 /нэг сая гурван зуун дөчин хоёр мянга есөн зуун/ төгрөгийг Санхүү, удирдлагын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Б.Нямбаяраар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/-т хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 182/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/85/НА - СТА - ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хувь хүнд шилжүүлсэн 22-45 СЭҮ улсын дугаартай "Хьюндай киа мохавэ" маркын тээврийн хэрэгслийн 2023-2025 онуудын тээврийн хэрэгслийн албан татвар 212,620.00 /хоёр зуун арван хоёр мянга зургаан зуун хорин/ төгрөгийг байгууллагаас төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хувь хүний хөрөнгийн татварт төлсөн 212,620.00 /хоёр зуун арван хоёр мянга зургаан зуун хорин/ төгрөгийг Санхүү, удирдлагын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Б.Нямбаяраар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/-т хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akt\2026\0316 SAG-29.Docx

1526200235



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 839/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/85/НА -СТА -ТӨҮГ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Авлагын товчоо тайланд тусгагдсан 176 харилцагч байгууллагын 7,892,484,290.00 /долоон тэрбум найман зуун ерэн хоёр сая дөрвөн зуун наян дөрвөн мянга хоёр зуун ерэн төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил давтагдсан байна

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэх, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй материал хариуцсан нягтлан бодогч /Д.Отгонбаяр/-т хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 840/150185

Улаанбаатар хот

САГ-2026/85/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хуулийн хэлтэс нь 90 харилцагчтай холбоотой 44,212,621,200.00 /дөчин дөрвөн тэрбум хоёр зуун арван хоёр сая зургаан зуун хорин нэгэн мянга хоёр зуун/төгрөгийн авлагыг барагдуулах ажлыг хариуцаж хийхээс, тайлант онд 0.1 хувь буюу 49,312,200.00 /дөчин есөн сая гурван зуун арван хоёр мянга хоёр зуун/ төгрөгийн авлага барагдсан, 38,688,100.00 /гучин найман сая зургаан зуун наян найман мянга нэг зуун/ төгрөгийн авлагын шүүхийн шийдвэр гарсан бөгөөд авлагыг барагдуулах хангалттай арга хэмжээ аваагүй байна. Мөн Шүүхэд хүргүүлсэн 17 нэхэмжлэл холбогдох баримт материал хангалтгүйгээс буцаж, тэмдэгтийн хураамжид 9,845,300.00 /есөн сая найман зуун дөчин таван мянга гурван зуун/ төгрөгийг төлж, үр ашиггүй зардал гаргасан байна. Компанийн Удирдах зөвлөлөөс хүчин төгөлдөр мөрдөж байгаа дүрэм, журмуудын хэрэгжилтийг хянах талаар үүрэг өгсөн нь хэрэгжээгүй, тус компанийн хэмжээнд нийт хэдэн дүрэм, журам мөрдөж байгаа нь тодорхой бус байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;", Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-т "Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ", 208.1-т "Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ", 208.2-т "Үүрэг гүйцэтгэх хугацаа тогтоогоогүй буюу болзол тавиагүй, үүргийн шинж чанараас шалтгаалан түүнийг тодорхойлох боломжгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг хэдийд ч шаардах эрхтэй, үүрэг гүйцэтгэгч нэн даруй гүйцэтгэх үүрэгтэй байна", 219.1-д "Үүрэг гүйцэтгэгч хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч учирсан хохирлоо арилгуулахаар шаардах эрхтэй", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "хүлээн зөвшөөрөгдөхүйц байх", 4.1.3-т "үр ашигтай байх", 4.1.6-д "сахилга баттай байх", 4.1.7-д "бодитой байх", 4.1.9-д "хариуцлагатай байх", 4.2.1-т "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 4.2.2-т "хэмнэлтийн зорим нь иргэд, олон нийтийн ашиг сонирхолд нийцэж, тэдний дэмжлэгийг хүлээхүйц түвшинд тодорхойлогдсон байх", 4.2.3-т "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудитормын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн”, 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, хангалтгүй нотлох баримтгүйгээс үр ашиггүй зардал гаргадаг зөрчлийг арилгаж биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/, ерөнхий нягтлан бодогч бөгөөд санхүү, удирдлагын газрын даргын үүрэг гүйцэтгэгч /Б.Нямбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 841/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/85/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ, эрсдэлийн удирдлагын хэлтсээс 19 асуудлыг хянаж, зөвлөмжийг холбогдох газар, хэлтэст хүргүүлсэн боловч зөвхөн 3 асуудлын зөвлөмжийн биелэлт 73-76 хувьтай гэж дүгнэсэн. Үүнээс 16 асуудалд хамаарах зөвлөмжийн хэрэгжилтийн мэдээг гаргаагүй, дотоод хяналтаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, хариу арга хэмжээ авч мөрдөж ажилладаггүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-д "дотоод аудит" гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг", 69.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дотоод хяналтын үйл ажиллагааны үр дүнд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, байгууллагын дүрэм, батлагдсан журмын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/, ерөнхий нягтлан бодогч бөгөөд санхүү, удирдлагын газрын даргын үүрэг гүйцэтгэгч /Б.Нямбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9006189
ATA16037
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-53.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 842/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/85/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Түүврээр "Гөлтгөнө" нийлүүлэх 5,311,680,000.00 /таван тэрбум гурван зуун арван нэгэн сая зургаан зуун наян мянган/ төгрөгийн төсөвт өртөгтэй 2 багц нээлттэй тендер шалгаруулалтын баримт бичигт хяналт хийхэд тендерийн баримт бичгийг хуульд заасны дагуу архивлаагүй, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл үүссэн тохиолдолд журмын дагуу мэдүүлэх гэж заасан байтал үнэлгээний хорооны гишүүн бүр маягтаар мэдүүлсэн, үнэлгээний хороо тендерийг үнэлэхдээ 18 хоногийн дараа хуралдаж, шалгаруулсан, батлагдсан маягтын дагуу үнэлгээг хийгээгүй, үнэлгээний хорооны хурлын ирц 60 хувьтай оролцсон, Багц 1-д тээврийн хэрэгслийн шаардлага хангаагүй оролцогчийг шалгаруулсан гэх мэт зөрчил илэрсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т "Үнэлгээний хороо тендер нээсэн өдөр тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг эхлүүлнэ", Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаал "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар", А/254 дүгээр тушаал "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам"-ыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулдаггүй, түүнд тавих хяналт хангалтгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/, ерөнхий нягтлан бодогч бөгөөд санхүү, удирдлагын газрын даргын үүрэг гүйцэтгэгч /Б.Нямбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 243/АД150185

Улаанбаатар хот

САГ-2026/85/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус компанийн захиргааны бүтэц хэт олон орон тоотой байгаагаас удирдлагын тогтмол зардал өндөр гарч, бүтээгдэхүүний өртөг, компанийн ашигт ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна. Мөн санхүүгийн албаны бүтэц зохион байгуулалт оновчгүй, ажлын ачаалал тэнцвэргүй, зарим ажлын зохион байгуулалт давхардсан олон хүний оролцоотой байна. Тухайлбал цалин хөлсийг бодоход төлөвлөлтийн албаны 4 эдийн засагч хийдэг, суутгах тооцооллыг санхүүгийн албаны нягтлан бодогч хариуцдаг зэргээр олон хүний оролцоо нь хяналт алдагдах, ажил цалгардах зэргээс шалтгаалан цалин хөлс буруу бодох эрсдэл гарч байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.2-т "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох", 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох", 19.2-т "Төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан энэ хуульд заасан хангамж, үйл ажиллагааны хязгаарлалтыг чанд мөрдөх ажилд хяналт тавьж, удирдах ажлыг хэрэгжүүлнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тус албаны бүтэц зохион байгуулалтыг оновчтой зохион байгуулах, ажлын зохион байгуулалт давхардуулсан зөрчлийг арилгаж биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/, ерөнхий нягтлан бодогч бөгөөд санхүү, удирдлагын газрын даргын үүрэг гүйцэтгэгч /Б.Нямбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Т-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-53.Docx

1526181139



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 844/20150185

Улаанбаатар хот

САГ - 2026/85/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тайланг зөрүүтэй гаргасан, хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөртэй холбоотой зөрүүгийн тайлангийн тооцоолол хийгээгүй, санхүүгийн тайлан болон татварын тодорхойлолтоор татварын өрийн үлдэгдэл зөрүүтэй зэрэг татварын багц хуулийг мөрдөж ажиллаагүй байна.

Энэ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Энэ хуулийн 5.3-т заасан албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон, түүнчлэн гадаад улсаас олсон орлогод албан татвар ногдоно", Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журмын 1.2-т "Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан нь анхан шатны баримт, тооцоолол, ажлын баримтаар баталгаажиж, татварын албанд тайлагнасан аж ахуйн нэгжийн орлогын албан татварын ТТ-2 тайлангийн холбогдох дүнтэй нийцсэн байна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах," гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Татварын багц хуулийг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/, ерөнхий нягтлан бодогч бөгөөд санхүү, удирдлагын газрын даргын үүрэг гүйцэтгэгч /Б.Нямбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага туйруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264030

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-53.Docx

1526181141



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 846/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/85/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 3 орон сууцны байранд удирдлагууд оршин суудаг боловч түрээсийн гэрээ байгуулаагүй байна. Мөн түрээсийн гэрээ байгуулан ажилчид байрлаж байгаа нийт 6 орон сууцыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т "Төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага,"; 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.3-т "өмч, хөрөнгийг бусдад зүй бусаар ашиглуулсан" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хөрөнгийг санхүүгийн тайланд бүртгээгүй, түрээсийн гэрээ байгуулаагүй таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/, ерөнхий нягтлан бодогч бөгөөд санхүү, удирдлагын газрын даргын үүрэг гүйцэтгэгч /Б.Нямбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-53.Docx

1526181123



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 847/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/85/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитын явцад тээврийн хэрэгслийн данснаас түүвэрлэн 95 тээврийн хэрэгслийг хамруулан хяналтын тооллого хийхэд, 22 тээврийн хэрэгсэл эвдрэлтэй, ашиглалтгүй, 25 тээврийн хэрэгсэл тоногдсон, 2 тээврийн хэрэгсэл осолд орж ашиглах боломжгүй болсон, 7 тээврийн хэрэгсэл биетээр оршин байхгүй зэрэг нийт 4,648,555,910.00 /дөрвөн тэрбум зургаан зуун дөчин найман сая таван зуун таван мянга есөн зуун арван/ төгрөгийн ашиглалтгүй 56 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-д "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ." 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.2-т "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ашиглах боломжгүй болсон, биетээр байхгүй тээврийг хэрэгслийг дээд шатны байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/, ерөнхий нягтлан бодогч бөгөөд санхүү, удирдлагын газрын даргын үүрэг гүйцэтгэгч /Б.Нямбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 848/А/0150185

Улаанбаатар хот

САГ-2026/85/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгийн тооллогод ажиглалт хийхэд үйлдвэр, хэлтсүүдийн удирдлагуудад хөрөнгийг хариуцуулсан боловч эд хариуцагчийн карт байхгүй, хариуцаж байгаа хөрөнгөө мэдэхгүй, танихгүй, коджуулаагүй зэрэг хөрөнгийн ашиглалт хадгалалтад тавих хяналт сул, хөрөнгө дутагдах, солигдох эрсдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1-д энгийн хялбар, чанга хатуу байх", 4.1.6-д "сахилга баттай байх", 4.1.9-д "хариуцлагатай байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т "Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараахь эрх, үүрэгтэй: 1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.2-т "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Эд хариуцагчийн карт хөтлөөгүй, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажилладаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/, ерөнхий нягтлан бодогч бөгөөд санхүү, удирдлагын газрын даргын үүрэг гүйцэтгэгч /Б.Нямбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 849/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/85/НА - СТА-ТӨУГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн найдваргүй авлагын нөөц байгуулах журмыг шинэчлэн боловсруулж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, найдваргүй авлагын нөөц тооцох суурь болон хувь хэмжээг бодит байдалд нийцүүлэн тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд тусгагдсан 65,981,158,500.00 /жаран таван тэрбум есөн зуун наян нэгэн сая нэг зуун тавин найман мянга таван зуун/ төгрөгийн авлагын үлдэгдэлд 35,746,070,000.00 /гучин таван тэрбум долоон зуун дөчин зургаан сая далан мянган/ төгрөгийг найдваргүй авлагын нөөц байгуулж, авлагын цэвэр үлдэгдэл 30,235,089,000.00 /гучин тэрбум хоёр зуун гучин таван сая наян есөн мянган/ төгрөг хүртэл буурсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-д "үнэн зөв байх", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19.1-т "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/, ерөнхий нягтлан бодогч бөгөөд санхүү, удирдлагын газрын даргын үүрэг гүйцэтгэгч /Б.Нямбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-53.Docx

1526181129



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 850/А0150185

Улаанбаатар хот

САГ - 2026/25/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Сангийн яаманд худалдан авах ажиллагаатай холбоотой 9 гомдол ирүүлснээс 6 нь оролцогчийн гомдол үндэслэлтэй буюу захиалагчийн гаргасан шийдвэр буруу гэж үзэн дахин хянан үзэх шийдвэр ирүүлсэн бөгөөд тендер зохион байгуулалтын явц процессын алдаатай, үнэлгээний хороо холбогдох хууль, журмын дагуу ажиллаагүй, түүнд тавих захиалагчийн хяналт сул байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална", 48.2.3-т "үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавих", 48.2.9-д "энэ хуулийн 54.6-д заасан гүйцэтгэгчийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулдаггүй, түүнд тавих хяналт хангалтгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/, ерөнхий нягтлан бодогч бөгөөд санхүү, удирдлагын газрын даргын үүрэг гүйцэтгэгч /Б.Нямбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 851/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/85/НА-СТА-ТӨҮГ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй шилэн дансны цахим хуудсанд 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 удаагийн 105,000,000.00 /нэг зуун таван сая/ төгрөгийн орлого, 3 удаагийн 150,000,000.00 /нэг зуун таван сая/ төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүйг, 17 удаагийн 3,508,458,000.00 /гурван тэрбум таван зуун найман сая дөрвөн зуун таван найман мянган/ төгрөгийн орлого, 42 удаагийн 3,236,100,900.00 /гурван тэрбум хоёр зуун гучин зургаан сая нэг зуун мянга есөн зуун/ төгрөгийн зарлагын гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.10-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-53.Docx

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй Төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Батсүрэн, Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн С.Амартүвшин, авлага борлуулалтын нягтлан бодогч Б.Цэцэгдэлгэр нарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 852/А015 0185

Улаанбаатар хот

САГ-2026/85/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 18 харилцагчдад 1,375,875,761.00 /нэг тэрбум гурван зуун далан таван сая найман зуун далан таван мянга долоон зуун жаран нэгэн/ төгрөгийн борлуулалтын орлогын төлбөрийн баримтыг харилцагчдад шивж өгөөгүйгээс тус орлогыг татварт тайлагнаагүй буюу 137,587,576.00 /нэг зуун гучин долоон сая таван зуун наян долоон мянга таван зуун далан зургаан/ төгрөгийн НӨАТ-ын татвар төлөхөөс зайлсхийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Борлуулалтын орлогыг үнэн зөв тодорхойлоогүй, төлбөрийн баримтыг харилцагчдад шивж өгдөггүй, тус орлогыг татварт тайлагнаагүй, НӨАТ төлөхөөс зайлсхийсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/, ерөнхий нягтлан бодогч бөгөөд санхүү, удирдлагын газрын даргын үүрэг гүйцэтгэгч /Б.Нямбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 853/А0150185

Улаанбаатар хот

САГ - 2026/85/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын журналд үлдэгдэлтэй байгаа насжилт өндөртэй 3046 нэрийн 1,027,173 ширхэг 10,013,754,100.00 /арван тэрбум арван гурван сая долоон зуун тавин дөрвөн мянга нэг зуун/ төгрөгийн хэрэгцээнээс илүү барааг худалдан авч нөөцөлсөн байна. Мөн насжилт өндөртэй бараанд үнэ цэнийн бууралт тооцоогүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-д "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хэрэгцээнээс илүү бараа материал худалдан авч нөөцөлдөг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/, ерөнхий нягтлан бодогч бөгөөд санхүү, удирдлагын газрын даргын үүрэг гүйцэтгэгч /Б.Нямбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 854/АО150185

Улаанбаатар хот

САГ-2026/85/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд гэрээний үнийн дүнгээс хэтрүүлэн 16 харилцагчаас 5,980,735,700.00 /таван тэрбум есөн зуун наян сая долоон зуун гучин таван мянга долоон зуун/ төгрөгийн худалдан авалт хийсэн, 10 харилцагчаас 5,135,638,300.00 /таван тэрбум нэг зуун гучин таван сая зургаан зуун гучин найман мянга гурван зуун/ төгрөгийн худалдан авалтыг шууд гэрээ байгуулж гүйцэтгэн, нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргыг хэрэглээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 32 дугаар зүйлийн 32.1-д "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний дүнгээс хэтрүүлэн худалдан авалт хийдэг, нээлттэй тендер сонгон шалгаруулахгүйгээр шууд худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/, ерөнхий нягтлан бодогч бөгөөд санхүү, удирдлагын газрын даргын үүрэг гүйцэтгэгч /Б.Нямбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Бага тайруу 3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-53.Docx

1526181136



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 855/АД/15/0185

Улаанбаатар хот

САГ-2026/85/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажиллагсадтай холбоотой авлагын дансад цалингийн урьдчилгааг өндөр хэмжээтэй /5.0-15.0 сая төгрөгөөр/ олгосноос 40 иргэний 325,177,420.00 /гурван зуун хорин таван сая нэг зуун далан долоон мянга дөрвөн зуун хорин/төгрөгийн төлбөр барагдуулах хугацаа хэтэрсэн, мөн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, нягтлан бодох бүртгэлийг зохистой удирдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажиллагсад өндөр дүнтэй цалингийн урьдчилгаа олгодог, үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, жилийн эцэст авлага үүсгэдэг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цемент Шохой ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/, ерөнхий нягтлан бодогч бөгөөд санхүү, удирдлагын газрын даргын үүрэг гүйцэтгэгч /Б.Нямбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу 3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-53.Docx

1526181131



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 952/A0150185

Улаанбаатар хот

САГ - 2026/85/НА-СТА-ТӨҮГ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар хүргүүлсэн 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 776/A0150185 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд өглөгийн товчоо тайланд тусгагдсан 574 харилцагчтай холбоотой 20,909,666,600.00 /хорин тэрбум есөн зуун есөн сая зургаан зуун жаран зургаан мянга зургаан зуун/ төгрөгийн өр, 16,372,618,900.00 /арван зургаан тэрбум гурван зуун балан хоёр сая зургаан зуун арван найман мянга есөн зуун/ төгрөгийн зээлийн хүүгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, өр төлбөр хариуцсан нягтлан бодогч /Д.Энхсайхан/-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар-т ирүүлэхийг Цемент Шохой ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/-т даалгав.

САХИЛГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 953/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/85/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэх захирлын буруутай шийдвэрээр 7 ажилтны ажилгүй байсан хугацааны цалин болох 315,650,341.00 /гурван зуун арван таван сая зургаан зуун тавин мянга гурван зуун дөчин нэг/ төгрөгийг шүүхийн шийдвэрийн дагуу байгууллагаас төлж, буруу шийдвэр гаргасан этгээдээс авах авлага үүсгээгүй зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн буюу компанид хамааралгүй зардлыг бүртгэж, ашгийг бууруулсан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.9-д заасны дагуу "энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", 103.2-д "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар хохирол нөхөн төлүүлэх арга хэмжээг авч, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн Эрсдэлийн удирдлага, хяналтын газрын дарга /Л.Наранчимэг/-г даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-74.Docx

1526181343



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 954/А0150185

Улаанбаатар хот

САГ - 2026/85/НА - СТА - ТӨҮГ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент Шохой ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 32 харилцагчдад 514,889,100.00 /таван зуун арван дөрвөн сая найман зуун наян есөн мянга нэг зуун/ төгрөгийн борлуулалтын орлогын төлбөрийн баримтыг үндэслэх баримтгүй шивж, борлуулалтын орлогыг өсгөсөн, худалдан авагч байгууллага нь 51,488,900.00 /тавин нэгэн сая дөрвөн зуун наян найман мянга есөн зуун/ төгрөгийн НӨАТ-ын худалдан авалтын буцаалтыг үндэслэлгүйгээр хасуулсан, орлогыг санаатай нуун дарагдуулсан, гэмт хэргийн шинжтэй зөрчил илэрсэн.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах,", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах,", Татварын ерөнхий хуулийн 28.5 "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Борлуулалтын орлогын төлбөрийн баримтыг үндэслэх баримтгүй шивж, борлуулалтын орлогыг өсгөсөн санаатай үйлдэл гаргасан авлага, борлуулалт хариуцсан нягтлан бодогч /Д.Отгонбаяр/-т хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар¹т ирүүлэхийг Цемент Шохой ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Л.Ганбаатар/-т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, Ц.НАРАНЧИМЭГ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР В.ЭРДЭНЭЦОГТ
АУДИТЫН МЕНЕЖЕР Т.ОДОНЧИМЭГ
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

